



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 17-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр, Баасан гараг

| | |
|---|-------|
| <i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i> | 1 |
| <i>Хуралдааны товч тэмдэглэл:</i> | 2-21 |
| <i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i> | 22-56 |
| <hr/> | |
| <i>1.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2022.09.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэв/</i> | 24-34 |
| <i>2.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шинэтгэлийн бодлогын талаар/</i> | 35-56 |

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
11 дүгээр сарын 17-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 38 гишүүн хүрэлцэн ирж, 52.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 10 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адьяа, Ц.Анандбазар, Д.Батлут, Б.Баттөмөр, Б.Бейсен, Х.Булгантуяа, С.Ганбаатар, Н.Ганибал, Г.Дамдинням, Б.Жавхлан, Б.Жаргалмаа, Г.Мөнхцэцэг, Ц.Мөнхцэцэг, Н.Учрал, Л.Энх-Амгалан;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Б.Баярсайхан, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Сүхбаатар;

Тасалсан: Ж.Батсуурь, Ш.Раднаасэд, Ц.Сэргэлэн;

Хоцорсон: С.Амарсайхан -34 минут, Г.Амартүвшин -04 минут, С.Батболд -1 цаг 03 минут, Х.Болорчулуун -1 цаг 02 минут, Д.Ганбат -27 минут, Т.Доржханд -32 минут, Л.Мөнхбаатар -01 минут, Ц.Мөнх-Оргил -11 минут, Д.Өнөрболор -29 минут, Д.Сарангэрэл -12 минут, Б.Энхбаяр -19 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын гишүүдийн ирцийг танилцуулав./10:02-10:10/

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржоос ирүүлсэн албан бичгийг танилцуулав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагаа хангалтгүй байгаа талаар үг хэлж, энэ асуудлаар Хүний эрхийн дэд хороо болон Хууль зүйн байнгын хороо анхаарч ажиллахыг үүрэг болгов.

Нэг.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2022.09.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэв/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга И.Батчулуун, Нийслэлийн Мал эмнэлгийн газрын Мал, амьтны эрүүл мэндийн хэлтсийн дарга Ц.Гантөмөр, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Орчны бохирдол, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга Б.Мөнх-Эрдэнэ, мөн хэлтсийн мэргэжилтэн Б.Мөнхжаргал, “Азтай савар” төрийн бус байгууллагын тэргүүн Ц.Зориглон, мөн байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн Ц.Болормаа, эрх зүйч Э.Анударь, “Эм-Ди-Эс Энд ХаанЛекс” хуулийн фирмийн хуульч, “Монгол банхар” судлалын төвийн үүсгэн байгуулагч Д.Цэрэнханд, Монголын нохой судлалын холбооны тэргүүн А.Наранбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төслийн талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль,” гэсний дараа “Иргэний хууль, Зөвшөөрлийн тухай хууль,” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 2.3 дахь хэсэг нэмэх:

“2.3.Энэ хууль албаны нохойтой холбоотой харилцаанд хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 13
Бүгд: 41
68.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2, 3.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.2.“асран хамгаалагч” гэж гэрийн тэжээвэр амьтныг энэ хуульд заасан шаардлагад нийцүүлэн хоол, орон байраар хангах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах болон нохой, муурыг өөрийн нэр дээр бүртгүүлсэн иргэнийг;

3.1.6.“түр байрлуулан асрамжлах газар” гэж төөрсөн, олдсон нохой, муурыг асран хамгаалагчид нь хүлээлгэн өгөх хүртэл, эзэнгүй нохой, муурыг асран хамгаалагчтай болгох хүртэл хоол, орон байраар хангаж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулан түр хараа хяналтдаа байлгах зорилгоор энэ хуульд заасны дагуу зөвшөөрөл авсан ашгийн төлөө бус хуулийн этгээдийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 12
Бүгд: 41
70.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.8, 3.1.9, 3.1.10 дахь заалт нэмэх:

“3.1.8.“нохой, муур үржүүлэх” гэж нохой, муурыг нэг болон түүнээс дээш удаа үржүүлэхийг;

3.1.9.“нохой, муурын нэгдсэн бүртгэл” гэж нохой, муурын асран хамгаалагч, нохой муур үржүүлэгч болон түр байрлуулан асрамжлах газрын эрх, үүрэг үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болохтой холбоотой бүртгэлийн үйл ажиллагааг;

3.1.10.“Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж” гэж гэрийн тэжээвэр амьтанд урьдчилан сэргийлэх арга хэмжээ, оношилгоо, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, нохой, мууранд үржил хязгаарлах мэс ажилбар хийх, бичил чип суулгах, шаардлагатай тохиолдолд унтуулах үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан нэгжийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 39
Татгалзсан: 12
Бүгд: 41
70.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Гэрийн тэжээвэр амьтантай холбоотой харилцаанд баримтлах зарчим

4.1.Гэрийн тэжээвэр амьтантай холбоотой харилцаанд дараах зарчмыг баримтална:

4.1.1.энэрэнгүй хандах;

4.1.2.хүчирхийллээс ангид байлгах;

4.1.3.байгалиасаа өөрийн онцлогтой болохыг хүлээн зөвшөөрч, тэдгээрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, хамгаалах, халамжлах;

4.1.4.гэрийн тэжээвэр амьтныг гэршүүлэн тэжээж ирсэн Монголын ард түмний уламжлалт ахуй, ёс заншил, өв соёлын салшгүй нэг хэсэг болох үндэсний уугуул үүлдрийн нохойтой холбоотой өвөрмөц аж төрөх ёс, түүхэн уламжлалыг хадгалах, нандигнан өвлүүлэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 13
Бүгд: 41
68.3 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар бүлгийн гарчгийг “**ХОЁРДУГААР БҮЛЭГ.ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР АМЬТНЫ АСРАН ХАМГААЛАГЧ БОЛОХ ҮНДЭСЛЭЛ, АСРАН ХАМГААЛАГЧ, ТҮР ХАРАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**” гэж өөрчилж, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.Иргэнд гэрийн тэжээвэр амьтны асран хамгаалагч болох үндэслэл дараах байдлаар үүснэ:” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 14
Бүгд: 41
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “6.1-д заасан шаардлагаас гадна асран хамгаалагчийн” гэснийг “7 дугаар зүйлд заасан” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 6.3 дахь хэсэг нэмэх:

“6.3.Иргэн гэрийн тэжээвэр амьтны талаарх ойлголт авах зорилгоор сайн дураараа асран хамгаалагчийн сургалтад хамрагдаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

| | |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 29 |
| Татгалзсан: | 13 |
| Бүгд: | 42 |

69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “энэ хуулийн” гэсний өмнө “хот, суурин газарт” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 7.4 дэх хэсэг нэмэх:

“7.4.Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь хот, сууринаас бусад газарт энэ хуулийн 7.3-т заасан агуулга бүхий зөвлөмж, мэдээллийг өгнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

| | |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 29 |
| Татгалзсан: | 13 |
| Бүгд: | 42 |

69.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “хууль буюу гэрээгээр олгогдсон” гэснийг хасаж, мөн зүйлийн 8.1.2 дахь заалтын “хуульд заасны дагуу бусдад” гэснийг “худалдахаас бусад хэлбэрээр” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

| | |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 28 |
| Татгалзсан: | 14 |
| Бүгд: | 42 |

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2.3 дахь заалтын “нохой, муур төрснөөс хойш зургаагаас арван хоёр сарын дотор” гэснийг “нохой, мууранд” гэж, мөн зүйлийн 9.2.5 дахь заалтын “ялгадсыг” гэснийг “өтгөн ялгадсыг” гэж тус тус өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 9.4 дэх хэсэг нэмэх:

“9.4.Энэ хуулийн 9.2.3-т заасан үүрэг Монголын үндэсний уугуул үүлдрийн нохойны асран хамгаалагчид хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

| | |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 25 |
| Татгалзсан: | 17 |
| Бүгд: | 42 |

59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтад доор дурдсан агуулгатай тайлбар нэмэх:

“Тайлбар:Энэ заалт нохой салхилах зориулалтын талбайд хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 16
Бүгд: 42
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.7, 10.8 дахь хэсэг нэмэх:

“10.7.Энэ хуулийн 40.1.4-т заасан нохой, муурын нэгдсэн бүртгэлийн сан бүрдүүлэх, бүртгэл хөтлөх журамд дараах асуудлыг тусгана:

10.7.1.бичил чип суулгасан нохой, муурын асран хамгаалагчийн бүртгэл;

10.7.2.нохой, муур үржүүлэгч болон түр байрлуулан асрамжлах газрын бүртгэл;

10.7.3.нохой, муурын асран хамгаалагчийн сургалт явуулах хуулийн этгээдийн бүртгэл;

10.7.4.алдагдсан нохой, муурын бүртгэл.

10.8.Баг, хорооны Засаг дарга, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь бичил чип унших төхөөрөмжтэй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 16
Бүгд: 42
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “Асран хамгаалагч энэ хуулийн 10.1.2, 10.2.1-д заасан үндэслэлээр” гэснийг, 11.2 дахь хэсгийн “Сум,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 16
Бүгд: 42
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн “Нохой, муурын нэгдсэн бүртгэл” гэсэн гарчгийг “Нохой, муурыг бүртгэлд хамруулах, бичил чип суулгах” гэж өөрчилж, 10.1, 10.2 дахь хэсгийн “сум,” гэснийг тус тус хасаж, 10.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.4.Нохой, муурын хаягийн бүртгэл нь асран хамгаалагчийн байнга оршин суугаа газрын хаягаар, нохой, муур үржүүлэгч болон түр байрлуулан асрамжлах байрын оршин байгаа газрын хаягаар тус тус тодорхойлогдоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 10 цаг 27 минутаас хуралдааныг даргалав.

Л.Мөнхбаатар: 14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11.2 дахь хэсэг нэмэх:

“11.2.Хот, сууринаас бусад газарт нохой, муурын асран хамгаалагчаар бүртгүүлэхэд энэ хуулийн 11.1.3 дахь заалт хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2 дахь хэсгийн “сум, дүүргийн” гэснийг “нутаг дэвсгэр хариуцсан” гэж өөрчилж, мөн зүйлийн 14.3 дахь хэсгийн “эрх бүхий этгээдэд” гэсний дараах “гэрийн тэжээвэр амьтныг” гэснийг хасаж, мөн зүйлийн 14.4 дэх хэсгийн “тухайн амьтныг” гэсний дараа “олох,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 20
Бүгд: 41
51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15, 16 дугаар зүйлийг нэгтгэн 15 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл.Нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл

15.1.Нохой, муур үржүүлэх үйл ажиллагааг энэ хуульд заасны дагуу зөвшөөрөл авсан ашгийн төлөө хуулийн этгээд эрхэлнэ.

15.2.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 41.1.2-т заасны дагуу нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг гурван жилийн хугацаагаар олгоно.

15.3.Энэ хуулийн 15.2-т заасан зөвшөөрөл олгохоос татгалзсан бол татгалзсан үндэслэлийг тодорхой зааж бичгээр хариу өгнө.

15.4.Нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгч дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

15.4.1.зөвшөөрөл хүссэн өргөдөл;

15.4.2.энэ хуулийн 21.1.1-д заасан шаардлага хангасан нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа явуулах орон байрны хэмжээ, нөхцөл байдлыг харуулсан гэрэл зураг, хаягийн нотлох баримт;

15.4.3.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийн хуулбар;

15.4.4.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

15.4.5.үржүүлэх нохой, муурын төрөл, үүлдэр, хүйс, тоо толгой, чипний дугаарын мэдээлэл.

15.5.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа явуулах орон байрны нөхцөл байдалтай биечлэн танилцах эрхтэй.

15.6.Энэ хуулийн 41.1.5-д заасан нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх журамд дараах зүйлийг тусгана:

15.6.1.нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээнд тусгах мэдээлэл;

15.6.2.нохой, муурын үүлдэр;

15.6.1нохой, муурын үржүүлэх үйл ажиллагаа явуулах орон байрны эрүүл ахуйн шаардлага.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 14

Бүгд: 38

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 13
Бүгд: 38
65.8 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтын “энэ хуулийн 16.4-т заасны дагуу ирүүлсэн зөвшөөрөл хүссэн өргөдөл, түүнд хавсаргасан” гэснийг “энэ хуулийн 15.4-т заасны дагуу ирүүлсэн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 14
Бүгд: 38
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “асран хамгаалагчийн үүргийг” гэснийг “үүргийг асран хамгаалагчийн нэгэн адил” гэж өөрчилж, мөн зүйлийн 21.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.5.хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургууль, сургуулийн дотуур байр, эмнэлэг, сувиллаас 200 метрийн дотор нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа явуулахгүй байх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.1.8 дахь заалтыг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 23.2 дахь хэсэг нэмэх:

“23.2.Нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл дуусгавар болсон тохиолдолд зөвшөөрөл эзэмшиж байсан этгээд нохой, муур үржүүлэх үйл ажиллагааг нэн даруй зогсоож, хуулийн этгээдийн нэр дээр бүртгэлтэй нохой, муурыг иргэн, эсхүл энэ хуульд заасан зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд шилжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17

Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24, 25 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 20
Бүгд: 40
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24, 25 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн “Нохой, муурыг төрснөөс хойш 45 хоногийн” гэснийг “Нохой, муурын үр төлийг 60 хоногийн” гэж өөрчилж, мөн зүйлийн 26.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26.2.Нохой, муур үржүүлэгч нохой, муурын үр төлийг төрснөөс хойш гурван тун урьдчилан сэргийлэх тарилга болон туулгалтад хамруулсны дараа бусдад шилжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 19
Бүгд: 41
53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27 дахь хэсгийг энэ зүйлийн 27.1 дэх хэсгийн тайлбар болгон өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41

58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 27.4 дэх хэсэг нэмэх:

“27.4.Энэ хуулийн 41.1.6-д заасан эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэхэд дагаж мөрдөх журамд дараах зүйлийг тусгана:

27.4.1.эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээнд тусгах мэдээлэл;

27.4.2.түр байрлуулан асрамжлах газрын хөтлөх бүртгэл;

27.4.3.түр байрлуулан асрамжлах газар гэрийн тэжээвэр амьтан хүлээн авах, шилжүүлэх талаарх мэдээлэл.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 19

Бүгд: 41

53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 19

Бүгд: 42

54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “энэ хуулийн 17.1-17.4-т” гэснийг “энэ хуульд” гэж, мөн зүйлийн 29.3.1 дэх заалтын “энэ хуулийн 28.2-т заасны дагуу ирүүлсэн” гэснийг “эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 29.4 дэх хэсэг нэмэх:

“29.4.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа явуулах орон байрны нөхцөл байдалтай биечлэн танилцах эрхтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 18

Бүгд: 42

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийн “асран хамгаалагчийн үүргийг” гэснийг “үүргийг асран хамгаалагчийн нэгэн адил” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 22

Бүгд: 42
47.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 16
Бүгд: 43
62.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийн “асран хамгаалагчийн үүргийг” гэснийг “үүргийг асран хамгаалагчийн нэгэн адил” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 15
Бүгд: 43
65.1 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 20
Бүгд: 43
53.5 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“34.3.Хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургууль, сургуулийн дотуур байр, эмнэлэг, сувиллаас 400 метрийн дотор эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 23
Бүгд: 43
46.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 15
Бүгд: 43
65.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“34.3.Хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургууль, сургуулийн дотуур байр, эмнэлэг, сувиллаас 400 метрийн дотор эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 37, 38 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 24
Бүгд: 43
44.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 37, 38 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалтын “тухайлан тусгаж хэрэгжүүлэх;” гэснийг “тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавих;” гэж, 40.1.3 дахь заалтын “боловсруулах.” гэснийг “батлах;” гэж тус тус өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 40.1.4 дэх заалт нэмэх:

“40.1.4.Нохой, муурын бүртгэлийн сан бүрдүүлэх, бүртгэл хөтлөх журмыг аймаг, нийслэлийн Засаг дарга болон Цагдаагийн байгууллагын саналыг авч батлах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 41 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“41 дүгээр зүйл.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

41.1.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гэрийн тэжээвэр амьтны талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

41.1.1.нохой, муурын нэгдсэн бүртгэл хөтлөх, бүртгэлийн систем хөгжүүлэх;

41.1.2.нохой, муур үржүүлэх болон эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хугацааг сунгах;

41.1.3.нохой, муур үржүүлэгч болон түр байрлуулан асрамжлах газрын нэгдсэн бүртгэл хөтлөх;

41.1.4.нохой, муур үржүүлэх болон эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа энэ хуульд заасан шаардлага, журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих;

41.1.5.нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх журмыг батлах, түүний биелэлтийг хангуулах;

41.1.6.эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх журмыг батлах, түүний биелэлтийг хангуулах;

41.1.7.нохой, муурын асран хамгаалагчийн сургалт зохион байгуулах хуулийн этгээдийг бүртгэх;

41.1.8.нохой, муурыг түр байрлуулан асрамжлах газрын эрүүл ахуйн хөтөлбөрийг бүртгэж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах;

41.1.9.гэрийн тэжээвэр амьтны тухай хууль тогтоомжийг сурталчлах, гэрийн тэжээвэр амьтантай холбоотой иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх ажлыг тасралтгүй явуулах.

41.2.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 20.2, 31.2-т заасан мэдээллийг нийтэд ил тод мэдээлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 42 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “бүртгэл хөтлөх,” гэсний дараа “бичил чип унших төхөөрөмжөөр” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 44 дүгээр зүйлийн 44.1.1 дэх заалтын “хууль тогтоомжийн” гэснийг “хууль тогтоомжийг сурталчлах,” гэж, 44.1.2 дахь заалтын “бүртгэл хөтлөх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах” гэснийг “үржлийг хязгаарлах, бичил чип суулгах ажлыг зохион байгуулах.” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 44.1.4 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 18
Бүгд: 43
58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 47 дугаар зүйлийн 47.2.1 дэх заалтын “харгис хэрцгийгээр” гэснийг хасаж, 47.2.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“47.2.3.эзэнгүй амьтны тоо толгойг бууруулах, гэрийн тэжээвэр амьтан нь эдгэшгүй өвчин, гэмтэлтэй, орчин тойрондоо аюултайгаас бусад тохиолдолд унтуулга хийх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсгийн “шагнал” гэсний өмнө “сугалаа” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсгийн “Иргэний хууль,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

42.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“52.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

43.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 52.2 дахь хэсэг нэмэх:

“52.2.Энэ хуулийн 12.4 дэх хэсгийг Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг хэрэглэх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан хугацаанаас хойш мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 21
Бүгд: 43
51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

44.Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.12 дахь заалт нэмэх:

“3.1.12.“нохойны удмын бичиг” гэж олон улсын байгууллагын албан ёсны гишүүн байгууллагаас олгодог тухайн нохойны гарал үүсэл, эцэг, эх, төрөлт, төрсөн огноо, хүйс, үүлдэр зэргийг заасан баримт бичгийг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 20
Бүгд: 43
53.5 хувийн саналаар дэмжигдлээ.

45.Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны гаргасан, Төслийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.4.6 дахь заалт нэмэх:

“15.4.6.цэвэр үүлдрийн нохойны хувьд удмын бичиг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

46.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар, эшлэлийг нийцүүлэн өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Найруулгын санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3.1.7 “энэ хуульд заасан журмын дагуу” гэснийг “энэ хуульд заасны дагуу”, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт “зүйлийн 18.1-г заасан эхний” гэснийг “хуулийн 18.1-г заасан бүртгэлийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 20
Бүгд: 43
53.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Нохой, эсхүл мууранд “гэснийг “Гэрийн тэжээвэр амьтны асран хамгаалагч, түр харагчийн нохой, мууранд” гэж өөрчилж, “бусад” гэсний дараах “гэрийн тэжээвэр амьтны асран хамгаалагч, түр харагчийн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “нэг нохой, эсхүл мууранд” гэснийг “нохой, муур тус бүрд бичил” гэж өөрчилж, мөн зүйлийн 11 дэх

хэсгийн “шагнал” гэсний өмнө “сугалаа,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 20
Бүгд: 43
53.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5 дугаар зүйлийн “5.1.55” гэснийг “5.1.57” гэж, “17 дугаар зүйлд” гэснийг “14 дүгээр зүйлд” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 21 дүгээр зүйлийн “21.1.38” гэснийг “21.1.48” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 19
Бүгд: 43
55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “6.10 дахь” гэснийг “6.44 дэх” гэж, “7.17” гэснийг “6.15” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 21
Бүгд: 43
51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Дөрөв.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “бүртгэж эрхэлнэ.” гэснийг “бүртгэж эхэлнэ.” гэж өөрчлөх, төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.4-д заасны дагуу нохой, муурын бүртгэлийн сан бүрдүүлэх, бүртгэл хөтлөх журмыг энэхүү хууль хүчин төгөлдөр болсноос хойш 6 сарын дотор баталж, нохой, муурын бүртгэлийн системийг нэг жилийн дотор хөгжүүлж, ашиглалтад оруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан” гэснийг “Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 21
Бүгд: 43
51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөлд доор дурдсан агуулгатай 9 дүгээр зүйл нэмэх:

“9 дүгээр зүйл.Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль хүчин төгөлдөр мөрдөхөөс өмнө үржил хязгаарлах мэс ажилбар хийлгээгүй найм болон түүнээс дээш настай нохой, муурын асран хамгаалагчид Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.3 дахь заалт хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 17
Бүгд: 43
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Үдээс өмнөх уралдаан 11 цаг 13 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 05 минутад эхлэв.

Хоёр.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шинэтгэлийн бодлогын талаар/

Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Солонгоо, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Дэд дарга бөгөөд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Хяналт шалгалтын газрын ахлах хянан шалгагч Т.Нармандах, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Эрдэнэбулган, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Н.Жамъянхүү, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын

хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Билэгдэмбэрэл, мөн яамны Цахим засаглалын хэлтсийн дарга Б.Золбоо, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн Албаны дарга Ч.Жаргалбаатар, мөн газрын Гүйцэтгэх ажлын хэлтсийн Албаны дарга Ч.Жаргалбаатар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга Л.Нямгэрэл, Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны дарга Э.Сэргэлэнбаатар, мөн албаны Эрэн сурвалжлах хэлтсийн дарга Д.Очгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, референт Ж.Лхагвасүрэн нар байлцав.

Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шинэтгэлийн бодлогын талаар мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан цөөнхийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл үг хэлэв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, О.Цогтгэрэл, Ц.Туваан нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Солонгоо нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.13-т заасны дагуу Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн Албаны дарга Ч.Жаргалбаатар нар хариулж, тайлбар хийв.

Чуулганы нэгдсэн хуралдаанд Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шинэтгэлийн бодлогын талаар мэдээлэл хийлээ.

Уг асуудлыг 15 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид болон Засаг даргын Тамгын газрын ажилтнууд Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 2 цаг 42 минут үргэлжилж, 72 гишүүнээс 50 гишүүн хүрэлцэн ирж, 69.4 хувийн ирцтэйгээр 16 цаг 44 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 10 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Бямбасүрэнгийн Энх-Амгалан 9.52, Нямаагийн Энх-Амгалан, Нямаагийн Энхболд 10.02, Жамбалын Ганбаатар 9.40, Хассуурийн Ганхуяг 9.22, Гочоогийн Ганболд 10.02, Цагаанхүүгийн Идэрбат 9.53, Нанзадын Наранбаатар 9.59, Мөнхөөгийн Оюунчимэг 9.56, Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн 3 минут 29 секунд хоцорлоо. Одонгийн Цогтгэрэл гишүүн 3 минут 47 секунд хоцорлоо. Гадаадад Засгийн газрын шийдвэр, олон улсын байгууллагын шугамаар болон бусад чиглэлээр Хүрэлбаатарын Булгантуяа, Бадарчийн Жаргалмаа, Цэрэнжамцын Мөнхцэцэг, Ням-Осорын Учрал нар гадаадад, орон нутагт Адьяаа, Анандбазар, Баттөмөр, Бейсен, Батлут, С.Ганбаатар, Наянтайн Ганибал, Гонгорын Дамдинням, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан нар, 2 гишүүн эмнэлгийн чөлөөтэй байна. 9 цагт ирсэн байна, 9.20 энд нэг 30 жилийн хурал эхэлсэн, 9.30-аас Хүний эрхийн Комиссын ажилтай танилцсан. Адьяасүрэнгийн, Амгалангийн Адьяасүрэн гишүүн 5 минут 36 секунд хоцорлоо. Дараагүй, яг тэр цагаар нь л хэлж байна. Шүүгээд үз, бичлэг үзэж болно, яг тэр тэр цагаар байгаа. Бат-Эрдэнэ гишүүн өглөө ирчихсэн байсан юм уу? Бат-Эрдэнэ гишүүн, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн 9.41-и ирж. Борхүүгийн Дэлгэрсайхан Зам тээврийн түгжрэлийн сайд 6 минут 44 секунд хоцорлоо. Уншсан, уншсан 6 минут хоцорсон. Пүрэвдорж гишүүн 9.53-аар орсон байна. Пүрэвдорж бол эрт ирж, хийдэг юм.

Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 17-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Зарчмын зөрүүтэй 53 саналтай, үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шинэтгэлийн бодлогын талаар мэдээлэл хийнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д заасны дагуу гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, асуудал нэмэх, дараалал өөрчлөх горимын санал гаргах болбол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдоржоос албан бичиг ирүүлсэн байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ. 10 секунд хүлээлээ алга байна. Дамдины Цогтбаатар ХЗБХ-ны дарга 11 минут 22 секунд хоцорлоо. Бүртгэлд алга байна. Тийм байна Цогтбаатар гишүүн уншуулсан байна, 10 цаг 00-р уншуулсан байна. Уучлаарай. Одоо нээрээ ачаалал ихтэй ажиллаж байгаа учраас гишүүд ирцээ чанд баримтална шүү. Энэ тасалсан, ирээгүй гишүүдийн нэрсийг гаргаад, Сахилга, хариуцлагын байнгын хороон дарга сар болгон мэдээлэл хийж байх ёстой. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар. Тэр дагуу олон нийтэд мэдээлж байх тийм дэгийн Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэмд Бат-Эрдэнэ гишүүнээ тэгж оруулсан байх аа, та байх үедээ. Ингээд Бөхчулууны Пүрэвдорж гишүүн алга байна.

Санал хураалтад орно. Санал хураалтад орохын өмнө бас цаг үеийн шинжтэй зарим асуудлаар анхааруулж хэлэх асуудлууд байна. Ард иргэд болон хүний эрхийн байгууллагуудаас ирсэн саналыг та бүхэнд уламжилж бас хэлнэ. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд хүний эрхийг хангах, хамгаалахтай холбоотой эрх зүй хийгээд соёлын шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж ирсэн ч гэсэн хүний эрх зөрчигдөх явдал гарсаар байна. Монгол Улс бол хүний эрх чөлөөний индексээр 165 орноос 51 дүгээрт эрэмбэлэгдэж байна. Монгол Улсын Их Хурлаас 2000 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийг анх баталсан. Ингэж манай улсад хүний эрхийг хангах, хамгаалах үндэсний тогтолцоог бий болгосон. Хүний эрхийн Комисс байгуулагдсан цагаас хойш манай улсад эрх нь зөрчигдөж хөндөгдөж эрсдэлд орж байгаа хүний эрхийн талаар нийтдээ 22 удаагийн илтгэлийг ирүүлсэн. Монгол Улсын Их Хурлаас хүний эрхийн үндэсний байгууллагуудын талаарх Парисын зарчимд нийцүүлэн Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийг 2020 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр шинэчлэн баталсан гэдгийг та бүхэн мэднэ. Энэ хуулиар олон чухал зарчмын өөрчлөлт хийсэн ч хуулийн хэрэгжилт төдийлөн сайнгүй байна. Би зөвхөн гуравхан зүйлийг дурдъя.

1 дүгээрт Улсын Их Хурал анх удаа өөрийнхөө эрхээс татгалзаж ХЭҮК-ын гишүүдийг иргэд олон нийтэд нээлттэй ил тод зарлаж, сонгон шалгаруулж томилдог болсон. Гишүүдийн тоог ч нэмэгдүүлсэн. Тэгээд гол зорилго бол хаана хүний эрхийн зөрчил байна түүнд хүрч, илрүүлж, иргэдийн дуу хоолой болж ажилладаг байгууллагыг төлөвшүүлэх асуудал юм. Гэтэл сүүлийн үед хүүхдийн эрх, хүний эрх, зөрчил шил дараалан гарах боллоо. Аливаа зүйл асуудалд үүссэн хойно нь биш үүсэхээс нь өмнө сануулдаг, шийдвэрлэдэг байх хандлагыг ХЭҮК-ыг төлөвшүүлж ажиллах үүрэг чиг хандлагыг өгсөн байдаг.

2 дугаарт Монгол Улсын ХЭҮК-ын тухай хуулийн шинэчлэлийн нэг зорилго бол Комиссын гишүүний шаардлага зөвлөмж заавал биелдэг байх зохицуулалт оруулсан. Өнгөрсөн хугацаанд комиссын гишүүний шаардлага зөвлөмжийг зүгээр нэг цаас мэтээр үздэг талаар шүүмжлэл гарсаар байсныг Улсын Их Хурал шийдвэрлэсэн. Өөрөөр хэлбэл, комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг биелүүлээгүй аливаа этгээдэд Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болдог байхаар хуульчилсан. Энэ зохицуулалтаа бол Хүний эрхийн Комиссын дарга нь болбол хэрэгжүүлж ажиллаж чадахгүй байна гэсэн ийм гомдол ирж байна.

3 дугаарт ХЭҮК жилд нэг илтгэл ирүүлдэг байгууллага баймааргүй байна. Жилд нэг л илтгэл ирүүлдэг, тэгээд л тэрнийг нь дагаад Улсын Их Хурал баахан дүгнэлт, тогтоол баталдаг. Тэгээд тэрнийгээ хэрэгжүүлдэггүй. Ийм учраас ХЭҮК-ын энэ асуудлыг ХЗБХ, Хүний эрхийн дэд хороо өнөөдөр Цогтбаатар дарга авч хэлэлцсэн. Энэ 7 хоногт бол. Ингээд эцэст нь хэлэхэд бол хүний эрхийн асуудлыг хамгийн түрүүнд тавьж хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг бүр хангахыг хууль хэрэгжүүлдэг бүх байгууллагуудад сануулж, энэ чиглэлээр гаргасан хууль тогтоомжоо хэрэгжүүлэх талаар ХЭҮК манлайлж ажиллах шаардлагатай. Шаардлагатай бол Хүний эрх эрхийн үндэсний комиссын даргаа өөрчлөх, солих хэрэгтэй. Тийм учраас энэ чиглэлээр Хүний эрхийн дэд хороо, ХЗБХ ажиллана.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё. Дэгийн тухай хуулийн дагуу горимын саналыг өмнөх өдрийн 17 цагаас өмнө бичгээр ирүүлсний дагуу ирдэг болсон. Энэ бол байгууллагуудаас ирсэн саналыг танилцууллаа. Ингээд хэлэлцэх асуудалдаа орно. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Горимын санал Улсын Их Хурлын

чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу өмнөх өдрийн 17 цагаас өмнө бичгээр санал ирүүлж байж шийдэх, горимын санал гэж хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, нэмэх, зөрчөөд биш би Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу ирсэн саналуудыг Улсын Их Хурлын чуулганд мэдээлэх үүрэгтэй. Тэр дагуу яаж байгаа. Тэр талтай холбогдуулаад горимын санал өгөхөөр дэг зөрчих гээд байна л даа, тийм дэг тогтоож болохгүй. Та өөр асуудал дээр би танд үг өгөөд, тэрэн дээр та холбогдуулж хэлж болно.

Нэг.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2022.09.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэв/

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулаад гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан юм байна. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 53 санал байгаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Идэрийн Батчулуун Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, Батбаярын Мөнх-Эрдэнэ Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Орчны бохирдол, хог хаягдлын удирдлагын хэлтсийн дарга, Цэдээгийн Гантөмөр Нийслэлийн Мал эмнэлгийн газрын Мал, амьтны эрүүл мэндийн хэлтсийн дарга, Бандийн Мөнхжаргал Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны Орчны бохирдол, хог хаягдлын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн, Цогийн Зориглон Азтай савар ТББ-ын тэргүүн, Цэвэлмаагийн Болормаа Азтай савар ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүн, Энхбаярын Аңударь Азтай савар ТББ-ын эрх зүйч, Мөнгөний Ариунзул Эм Ди Эс

Энд Хаан Лекс хуулийн фирмийн хуульч, Нямдоржийн Баясгалан Өмгөөллийн Легал Гайд хуулийн фирмийн хуульч, Дэлгэрийн Цэрэнханд Монгол банхар судлалын төвийг үүсгэн байгуулагч, Амгаланбаатарын Наранбаяр Монгол, Монголын нохой судлалын холбооны тэргүүн.

Ингээд зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Байгаль орчны БОХХАА-н байнгын хорооны дэмжсэн санал байна.

1.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль,” гэсний дараа “Иргэний хууль, Зөвшөөрлийн тухай хууль,” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 2.3 дахь хэсэг нэмэх:

“2.3.Энэ хууль албаны нохойтой холбоотой харилцаанд хамаарахгүй.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар, Тилеуханы Аубакир, Энхбаярын Батицугар, Гонгорын Дамдинням, Цэвэгдоржийн Туваан цаашид “Ажлын хэсэг” гэнэ. Санал хураалтад бэлдье. Ганбаатар сайд суудалдаа сууя. Санал хураалт. 68.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.2, 3.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.2.“асран хамгаалагч” гэж гэрийн тэжээвэр амьтныг энэ хуульд заасан шаардлагад нийцүүлэн хоол, орон байраар хангах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах болон нохой, муурыг өөрийн нэр дээр бүртгүүлсэн иргэнийг;

3.1.6.“түр байрлуулан асрамжлах газар” гэж төөрсөн, олдсон нохой, муурыг асран хамгаалагчид нь хүлээлгэн өгөх хүртэл, эзэнгүй нохой, муурыг асран хамгаалагчтай болгох хүртэл хоол, орон байраар хангаж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд

хамруулан түр хараа хяналтдаа байлгах зорилгоор энэ хуульд заасны дагуу зөвшөөрөл авсан ашгийн төлөө бус хуулийн этгээдийг;" Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 70.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.8, 3.1.9, 3.1.10 дахь заалт нэмэх:

“3.1.8. “нохой, муур үржүүлэх” гэж нохой, муурыг нэг болон түүнээс дээш удаа үржүүлэхийг;

3.1.9. “нохой, муурын нэгдсэн бүртгэл” гэж нохой, муурын асран хамгаалагч, нохой муур үржүүлэгч болон түр байрлуулан асрамжлах газрын эрх, үүрэг үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болохтой холбоотой бүртгэлийн үйл ажиллагааг;

3.1.10. “Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж” гэж гэрийн тэжээвэр амьтанд урьдчилан сэргийлэх арга хэмжээ, оношилгоо, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, нохой, мууранд үржил хязгаарлах мэс ажилбар хийх, бичил чип суулгах, шаардлагатай тохиолдолд унтуулах үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан нэгжсийг;” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Ганбаатар сайдаа санал хураалт. 70,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Гэрийн тэжээвэр амьтантай холбоотой харилцаанд баримтлах зарчим

4.1.Гэрийн тэжээвэр амьтантай холбоотой харилцаанд дараах зарчмыг баримтална:

4.1.1 .энэрэнгүй хандах;

4.1.2.хүчирхийллээс ангид байлгах;

4.1.3.байгалиасаа өөрийн онцлогтой болохыг хүлээн зөвшөөрч, тэдгээрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, хамгаалах, халамжлах;

4.1.4.гэрийн тэжээвэр амьтныг гэршүүлэн тэжээж ирсэн Монголын ард түмний уламжлалт ахуй, ёс заншил, өв соёлын салиггүй нэг хэсэг болох үндэсний уугуул үүлдрийн нохойтой холбоотой өвөрмөц аж төрөх ёс, түүхэн уламжлалыг хадгалах, нандигнан өвлүүлэх.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 68,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 2 дугаар бүлгийн гарчгийг “ХОЁРДУГААР БҮЛЭГ.ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР АМЬТНЫ АСРАН ХАМГААЛАГЧ БОЛОХ ҮНДЭСЛЭЛ, АСРАН ХАМГААЛАГЧ, ТҮР ХАРАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ” гэж өөрчилж, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.Иргэнд гэрийн тэжээвэр амьтны асран хамгаалагч болох үндэслэл дараах байдлаар үүснэ:” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 65,9 хувийн саналаар санал дэмжигдлээ. 5.Төслийн 2 дугаар бүлгийн гарчгийг “ХОЁРДУГААР БҮЛЭГ.ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР АМЬТНЫ АСРАН ХАМГААЛАГЧ БОЛОХ ҮНДЭСЛЭЛ, АСРАН ХАМГААЛАГЧ, ТҮР ХАРАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ” гэж өөрчилж, хураасан.

6.Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “6.1-д заасан шаардлагаас гадна асран хамгаалагчийн” гэснийг “7 дугаар зүйлд заасан” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 6.3 дахь хэсэг нэмэх:

“6.3.Иргэн гэрийн тэжээвэр амьтны талаарх ойлголт авах зорилгоор сайн дураараа асран хамгаалагчийн сургалтад хамрагдаж болно.” Санал

гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 69 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “энэ хуулийн” гэсний өмнө “хот, суурин газарт” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 7.4 дэх хэсэг нэмэх:

“7.4.Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь хот, сууринаас бусад газарт энэ хуулийн 7.3-т заасан агуулга бүхий зөвлөмж, мэдээллийг өгнө.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 69 хувийн саналаар санал дэмжигдээд байна.

8.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “хууль буюу гэрээгээр олгогдсон” гэснийг хасаж, мөн зүйлийн 8.1.2 дахь заалтын “хуульд заасны дагуу бусдад” гэснийг “худалдахаас бусад хэлбэрээр” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 66,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.2.3 дахь заалтын “нохой, муур төрснөөс хойш зургаагаас арван хоёр сарын дотор” гэснийг “нохой, мууранд” гэж, мөн зүйлийн 9.2.5 дахь заалтын “ялгадсыг” гэснийг “өтгөн ялгадсыг” гэж тус тус өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 9.4 дэх хэсэг нэмэх:

“9.4.Энэ хуулийн 9.2.3-т заасан үүрэг Монголын үндэсний уугуул үүлдрийн нохойны асран хамгаалагчид хамаарахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 59,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтад доор дурдсан агуулгатай тайлбар нэмэх:

“Тайлбар:энэ заалт нохой салхилах зориулалтын талбайд хамаарахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 61,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Төслийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.7, 10.8 дахь хэсэг нэмэх:

“10.7.Энэ хуулийн 40.1.4-т заасан нохой, муурын нэгдсэн бүртгэлийн сан бүрдүүлэх, бүртгэл хөтлөх журамд дараах асуудлыг тусгана:

10.7.1.бичил чип суулгасан нохой, муурын асран хамгаалагчийн бүртгэл;

10.7.2.нохой, муур үржүүлэгч болон түр байрлуулан асрамжлах газрын бүртгэл;

10.7.3.нохой, муурын асран хамгаалагчийн сургалт явуулах хуулийн этгээдийн бүртгэл;

10.7.4.алдагдсан нохой, муурын бүртгэл.

10.8.Баг, хорооны Засаг дарга, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь бичил чип унших төхөөрөмжтэй байна.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Мөнхбаатар даргаа. 61,9 хувийн саналаар санал дэмжигдлээ. Асуудал нь нохой, муурдаа биш, нохой, муурнаас дор хүмүүс байгаад л асуудал байгаа зарим нэг.

13.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “Асран хамгаалагч энэ хуулийн 10.1.2, 10.2.1-д заасан үндэслэлээр” гэснийг, 11.2 дахь хэсгийн “Сум,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Л.Мөнхбаатар: 61,9 хувиар санал дэмжигдлээ. 11.Төслийн 10 дугаар зүйлийн “Нохой, муурын нэгдсэн бүртгэл” гэсэн гарчгийг “Нохой, муурыг бүртгэлд хамруулах, бичил чип суулгах” гэж өөрчилж, 10.1, 10.2 дахь хэсгийн “сум,” гэснийг тус тус хасаж, 10.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.4.Нохой, муурын хаягийн бүртгэл нь асран хамгаалагчийн байнга оршин суугаа газрын хаягаар, нохой, муур үржүүлэгч болон түр байрлуулан асрамжлах байрын оршин байгаа газрын хаягаар тус тус тодорхойлогдоно.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 59,5 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11.2 дахь хэсэг нэмэх:

“11.2.Хот, сууринаас бусад газарт нохой, муурын асран хамгаалагчаар бүртгүүлэхэд энэ хуулийн 11.1.3 дахь заалт хамаарахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 57,5 хувиар санал дэмжигдлээ.

15.Төслийн 12 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 56,1 хувиар санал дэмжигдлээ.

16.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2 дахь хэсгийн “сум, дүүргийн” гэснийг “нутаг дэвсгэр хариуцсан” гэж өөрчилж, мөн зүйлийн 14.3 дахь хэсгийн “эрх бүхий этгээдэд” гэсний дараах “гэрийн тэжээвэр амьтныг” гэснийг хасаж, мөн зүйлийн 14.4 дэх хэсгийн “тухайн амьтныг” гэсний дараа “олох,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 51,2 хувиар санал дэмжигдлээ.

17.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 61,5 хувиар санал дэмжигдлээ.

18.Төслийн 15, 16 дугаар зүйлийг нэгтгэн 15 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл.Нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл

15.1.Нохой, муур үржүүлэх үйл ажиллагааг энэ хуульд заасны дагуу

зөвшөөрөл авсан ашгийн төлөө хуулийн этгээд эрхэлнэ.

15.2.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 41.1.2-т заасны дагуу нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг гурван жилийн хугацаагаар олгоно.

15.3.Энэ хуулийн 15.2-т заасан зөвшөөрөл олгохоос татгалзсан бол татгалзсан үндэслэлийг тодорхой зааж бичгээр хариу өгнө.

15.4.Нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэгч дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

15.4.1.зөвшөөрөл хүссэн өргөдөл;

15.4.2.энэ хуулийн 21.1.1-д заасан шаардлага хангасан нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа явуулах орон байрны хэмжээ, нөхцөл байдлыг харуулсан гэрэл зураг, хаягийн нотлох баримт;

15.4.3.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрмийн хуулбар;

15.4.4.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

15.4.5.үржүүлэх нохой, муурын төрөл, үүлдэр, хүйс, тоо толгой, чипний дугаарын мэдээлэл.

15.5.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа явуулах орон байрны нөхцөл байдалтай биечлэн танилцах эрхтэй.

15.6.Энэ хуулийн 41.1.5-д заасан нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх журамд дараах зүйлийг тусгана:

15.6.1.нохой, муур
үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрлийн гэрчилгээнд тусгах
мэдээлэл;

15.6.2.нохой, муурын
үүлдэр;

15.6.1нохой, муурын
үржүүлэх үйл ажиллагаа явуулах орон
байрны эрүүл ахуйн шаардлага.” Санал
гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.
63,2 хувиар санал дэмжигдлээ.

19.Төслийн 17 дугаар зүйлийг
хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал
хураалт. 65,8 хувиар санал дэмжигдлээ.

20.Төслийн 18 дугаар зүйлийн
18.1.1 дэх заалтын “энэ хуулийн 16.4-т
заасны дагуу ирүүлсэн зөвшөөрөл хүссэн
өргөдөл, түүнд хавсаргасан” гэснийг “энэ
хуулийн 15.4-т заасны дагуу ирүүлсэн”
гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын
хэсэг. Санал хураалт. 63,2 хувиар санал
дэмжигдлээ.

21.Төслийн 19 дүгээр зүйлийг
хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал
хураалт. 52,6 хувиар санал дэмжигдлээ.

22.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2
дахь хэсгийн “асран хамгаалагчийн
үүргийг” гэснийг “үүргийг асран
хамгаалагчийн нэгэн адил” гэж өөрчилж,
мөн зүйлийн 21.1.5 дахь заалтыг доор
дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.5.хүүхдийн цэцэрлэг,
бүх шатны сургууль, сургуулийн дотуур
байр, эмнэлэг, сувиллаас 200 метрийн
дотор нохой, муур үржүүлэх үйл
ажиллагаа явуулахгүй байх;” Санал
гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.
60,5 хувиар санал дэмжигдлээ.

23.Төслийн 23 дугаар зүйлийн
23.1.8 дахь заалтыг хасаж, мөн зүйлд
доор дурдсан агуулгатай 23.2 дахь хэсэг
нэмэх:

“23.2.Нохой, муур үржүүлэх үйл
ажиллагаа эрхлэх зөвшөөрөл дуусгавар
болсон тохиолдолд зөвшөөрөл эзэмшиж
байсан этгээд нохой, муур үржүүлэх үйл
ажиллагааг нэн даруй зогсоож, хуулийн
этгээдийн нэр дээр бүртгэлтэй нохой,
муурыг иргэн, эсхүл энэ хуульд заасан
зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд
шилжүүлнэ.” Санал гаргасан ажлын
хэсэг, санал хураалт. 56,4 хувиар санал
дэмжигдлээ.

24.Төслийн 24, 25 дугаар зүйлийг
хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал
хураалт. Энэ санал уналаа.
Баднямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн
горимын санал гаргая.

Б.Бат-Эрдэнэ: Би уг нь дэмжиж
санал өгсөн юм. Миний төхөөрөмж
гацаад татгалзсанаар гарчихлаа. Энэ
саналыг дахин хураалгаж өгнө үү. Санал
хураалгаж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын
гишүүн Бадмаанямбуугийн Бат-
Эрдэнийн гаргасан горимын саналаар
саяын санал хураалтыг хүчингүйд тооцох
санал хураалт явуулъя. Санал хураалт
гишүүдээ. Анхааралтай өгөөрэй. 57,5
хувиар санал дэмжигдлээ. Саяын санал
хураалт хүчингүй болсон. Өмнөх санал
хураалтын томъёоллыг уншиж
танилцуулсан байгаа. Ингээд үндсэн
санал хураалтыг явуулъя. Санал хураалт.
55 хувиар санал дэмжигдлээ.

25.Төслийн 26 дугаар зүйлийн 26.3
дахь хэсгийн “Нохой, муурыг төрснөөс
хойш 45 хоногийн” гэснийг “Нохой,
муурын үр төлийг 60 хоногийн” гэж
өөрчилж, мөн зүйлийн 26.2 дахь хэсгийг
доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26.2.Нохой, муур үржүүлэгч
нохой, муурын үр төлийг төрснөөс хойш
гурван тун урьдчилан сэргийлэх тарилга
болон туулгалтад хамруулсны дараа
бусдад шилжүүлнэ.” Гурван тун гэдэг нь
одоо хуульчилж болдог зүйл юм уу. Нохой,
муурын үржүүлэгчийн, үржүүлэгч нохой,

муурын үр төлийг төрснөөс хойш гурван урьдчилан сэргийлэх тарилга болон туулгалтад хамруулсны дараа бусдад шилжүүлнэ гэж байгаа юм. Ийм зүйлийг хуульчилж болох юм байх даа. Санал хураалт. Санал гаргасан ажлын хэсэг гэж байна. 53,7 хувиар санал дэмжигдлээ.

26.Төслийн 27 дугаар зүйлийн 27 дахь хэсгийг энэ зүйлийн 27.1 дэх хэсгийн тайлбар болгон өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58,5 хувиар санал дэмжигдлээ.

27.Төслийн 27 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 27.4 дэх хэсэг нэмэх:

“27.4.Энэ хуулийн 41.1.6-д заасан эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэхэд дагаж мөрдөх журамд дараах зүйлийг тусгана:

27.4.1.эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээнд тусгах мэдээлэл; тусгах мэдээлэл.

27.4.2.түр байрлуулан асрамжлах газрын бүртгэл, хөтлөх бүртгэл;

27.4.3.түр байрлуулан асрамжлах газар гэрийн тэжээвэр амьтан хүлээн авах, шилжүүлэх талаарх мэдээлэл.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 53,7 хувиар санал дэмжигдлээ.

28.Төслийн 28 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 54,8 хувиар санал дэмжигдлээ.

29.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “энэ хуулийн 17.1-17.4-т” гэснийг “энэ хуульд” гэж, мөн зүйлийн 29.3.1 дэх заалтын “энэ хуулийн 28.2-т заасны дагуу ирүүлсэн” гэснийг “эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх” гэж өөрчилж, мөн

зүйлд доор дурдсан агуулгатай 29.4 дэх хэсэг нэмэх:

“29.4.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа явуулах орон байрны нөхцөл байдалтай биечлэн танилцах эрхтэй.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 57,1 хувиар санал дэмжигдлээ.

30.Төслийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийн “асран хамгаалагчийн үүргийг” гэснийг “үүргийг асран хамгаалагчийн нэгэн адил” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Санал хураалт гишүүдээ. Цэвэгдоржийн Туваан гишүүн горимын санал гаргая.

Ц.Туваан: Мөнхбаатар даргаа сая дэмжиж санал өгсөн, тэгээд эсрэг гарчихлаа. Энэ санал хураалтыг хүчингүйд тооцож өгнө үү. Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Тувааны гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүдээ. 62,8 хувиар санал дэмжигдлээ. Түрүүний санал хураалт хүчингүй болсон. Үндсэн санал хураалтын томъёоллыг уншиж та бүхэнд танилцуулсан байгаа. Санал хураалт явуулъя. 65,1 хувиар санал дэмжигдлээ.

31.Төслийн 30 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 53,5 хувиар санал дэмжигдлээ.

32.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“34.3.Хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургууль, сургуулийн дотуур байр, эмнэлэг, сувиллаас 400 метрийн дотор эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Асуулт бол байхгүй.

Дэмжсэн 3, дэмжээгүй 3 гишүүн уг хэлж болно саналын томъёолол дээр. Санал дэмжигдсэнгүй. Цаашаа явах уу? 32 дахь санал уначхаад байна даа. Ийм агуулгатай л юм байна шүү дээ. Сургууль, цэцэрлэг, дотуур байр, эмнэлэг, сувиллаас 400 метрийн дотор эзэнгүй амьтан түр байрлуулж асрамжлах үйл ажиллагаа явуулахыг хориглоно гэсэн ийм заалт байна шүү дээ. Уг нь чухал заалт л юм шиг байх юм. Гочоогийн Ганболд гишүүн горимын санал гаргая.

Г.Ганболд: Саяын санал хураалт дээр би уг нь дэмжсэн санал өгсөн. Тэгээд төхөөрөмж ажилласангүй. Дахин санал хураалт явуулж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Гочоогийн Ганболд гишүүний гаргасан горимын саналаар санал хураая. Саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. 65.1 хувиар санал дэмжигдлээ. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Үндсэн санал хураалтын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. Санал хураалт гишүүдээ. 60,5 хувиар санал дэмжигдлээ.

33.Төслийн 37, 38 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Аубакир гишүүн горимын санал гаргая. Гишүүд анхааралтай саналаа өгөөрэй. Аубакир гишүүн горимын санал гаргая.

Т.Аубакир: Саяын заалтыг дэмжиж санал өгсөн. Төхөөрөмж ажилласангүй дахин санал хурааж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Тилеуханы Аубакир гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүдээ. 55,8 хувиар санал дэмжигдлээ. Саяын санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Үндсэн санал хураалтыг явуулъя. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан байгаа.

Санал хураалт гишүүдээ. 58,1 хувиар санал дэмжигдлээ.

34.Төслийн 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалтын “тухайлан тусгаж хэрэгжүүлэх;” гэснийг “тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавих;” гэж, 40.1.3 дахь заалтын “боловсруулах.” гэснийг “батлах;” гэж тус тус өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 40.1.4 дэх заалт нэмэх:

“40.1.4.Нохой, муурын бүртгэлийн сан бүрдүүлэх, бүртгэл хөтлөх журмыг аймаг, нийслэлийн Засаг дарга болон Цагдаагийн байгууллагын саналыг авч батлах.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ хэн батлах юм бэ энэ? Аймаг, нийслэлийн Засаг дарга болон цагдаагийн байгууллагаас саналыг нь авчхаад батлах субъект нь хэн юм бэ? Ажлын хэсгийн ахлагч нь хэн байгаа билээ? Хэн батлах юм бэ энэ? 55,8 хувиар санал дэмжигдлээ.

35.Төслийн 41 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“41 дүгээр зүйл.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

41.1.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гэрийн тэжээвэр амьтны талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

41.1.1.нохой, муурын нэгдсэн бүртгэл хөтлөх, бүртгэлийн систем хөгжүүлэх;

41.1.2.нохой, муур үржүүлэх болон эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хугацааг сунгах;

41.1.3.нохой, муур үржүүлэгч болон түр байрлуулан асрамжлах газрын нэгдсэн бүртгэл хөтлөх;

41.1.4.нохой, муур үржүүлэх болон эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа энэ хуульд заасан шаардлага, журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих;

41.1.5.нохой, муур үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх журмыг батлах, түүний биелэлтийг хангуулах;

41.1.6.эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагаа эрхлэх журмыг батлах, түүний биелэлтийг хангуулах;

41.1.7.нохой, муурын асран хамгаалагчийн сургалт зохион байгуулах хуулийн этгээдийг бүртгэх;

41.1.8.нохой, муурыг түр байрлуулан асрамжлах газрын эрүүл ахуйн хөтөлбөрийг бүртгэж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах; Эрүүл ахуйн хөтөлбөрийг бүртгэх. Үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах.

41.1.9.гэрийн тэжээвэр амьтны тухай хууль тогтоомжийг сурталчлах, гэрийн тэжээвэр амьтантай холбоотой иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх ажлыг тасралтгүй явуулах.

41.2.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 20.2, 31.2-т заасан мэдээллийг нийтэд ил тод мэдээлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Саяынх хэдэн хувь байсан бэ? Түр байж байгаарай. Одоо программ шинэчлэгдээд орхиё. Болсон уу? Саналын томъёоллыг уншиж танилцуулсан, санал хураалт явуулъя гишүүдээ, санал хураалт. 55,8 хувиар санал дэмжигдлээ.

36.Төслийн 42 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60,5 хувиар санал дэмжигдлээ.

37.Төслийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “бүртгэл хөтлөх,” гэсний

дараа “бичил чип унших төхөөрөмжөөр” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55,8 хувиар санал дэмжигдлээ.

38.Төслийн 44 дүгээр зүйлийн 44.1.1 дэх заалтын “хууль тогтоомжийн” гэснийг “хууль тогтоомжийг сурталчлах,” гэж, 44.1.2 дахь заалтын “бүртгэл хөтлөх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах” гэснийг “үржлийг хязгаарлах, бичил чип суулгах ажлыг зохион байгуулах.” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 44.1.4 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 58,1 хувиар санал дэмжигдлээ.

39.Төслийн 47 дугаар зүйлийн 47.2.1 дэх заалтын “харгис хэрцгийгээр” гэснийг хасаж, 47.2.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“47.2.3.эзэнгүй амьтны тоо толгойг бууруулах, гэрийн тэжээвэр амьтан нь эдгэшигүй өвчин, гэмтэлтэй, орчин тойрондоо аюултайгаас бусад тохиолдолд унтуулга хийх;” Санал гаргасан ажлын хэсэг. Энэ дээр яах юм бэ та үг хэлэх юм уу? Санал хураалтыг түдгэлзүүлээд, үг хэлье. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн үг хэлье.

Д.Тогтохсүрэн: Яах вэ, бид энэ нөгөө би бол ингэж ойлгоод л байна. Энэ гарах ёстой хууль уу гэвэл гарах ёстой хууль энэ Гэрийн тэжээвэр амьтны хууль, зохицуулах шаардлага байгаа юу гэвэл шаардлага байгаа. Тэгээд 1 ийм харилцааны асуудлыг л зохицуулмаар байгаа юм. Манай Цогтбаатар дарга араас нь үг хэлээд явчихвал их сайн байгаа юм. Хамгийн их тулгамддаг нэг том ажил бол энэ аймаг, сумын дарга нарын зовлон л доо. Өөр ч хүн мэдэхгүй. Энэ эзэнгүй нохой устгах ажил байдаг байхгүй юу. Орчин тойрондоо асар их хэмжээний бохирдол үүсгэдэг, өвчин тараадаг, халдварт өвчин тараадаг, тэгээд хүн хүмүүсийг хазаж урдаг гээд ингээд ярих юм бол хамгийн их хөнөөлтэй байдаг л даа. Гэтэл энийг устгах ажлыг одоогийн

мөрдөж байгаа хуулиар бид, манай орон нутгийнхан зохион байгуулдаг Засаг дарга нар, багийн Засаг дарга, сумын Засаг дарга нар зохион байгуулаад л, тэгээд л анчин хөлслөөд л ингээд зохион байгуулж байгаа шүү дээ. Энэ арга хэмжээ цаашидаа би бол үргэлжилж бүүр их яах болов уу гэж бодоод байгаа байхгүй юу, зохион байгуулалтад ороод ингээд явах болов уу гэж бодоод байдаг байхгүй юу. Энэ аягүй их хэцүү. Нохойны мах болон нохойны нөгөө арьс борлогдохгүй байгаа үед тэрийг авдаг юм хаана ч байхгүй. Тэгэхээр тэрийг хэт олируулахгүй, нийгэмдээ аюултай байдал үүсгэхгүйн тулд л хийдэг л ажил байхгүй юу. Тийм учраас энэ арга хэмжээг зохион байгуулах юм энэ хууль гарснаар хаагдчихгүй байгаа даа гэж ингэж санаа зовж байгаа асуудал 1 дүгээрт нь байгаа юм.

2 дахь асуудал нь энэ дээрээс хараад байхаар нөгөө ийм эзэнгүй нохойны нохой биш ээ, ганц нохой биш, эзэнгүй амьтдын төв байгуулна эд нар гээд ингээд юмнууд бас байгаа юм. Энэний зардлын асуудлыг ер нь яаж шийдэх юм бэ? Энийг шийдэх ёстой юу гэвэл шийдэх ёстой мөн. Гэхдээ энэний зардлынх нь асуудал яах юм бэ, орон нутгийн төсөв дээр тусгаж явах юм уу, цаашидаа ямар хэлбэрээр явах юм бэ? Энийг бизнесийн харилцаанд нь оруулах юм руу явахгүй, дан орон нутгаараа явна гэвэл бас их хүндрэл учруулна энэ 2.

Л.Мөнхбаатар: Асуултад асуулт биш үг хэлэх ёстой л доо. Та яах юм үг хэлэх юм уу? Ажлын хэсгийн ахлагч Дамдины Цогтбаатар үг хэлье.

Д.Цогтбаатар: Тогтохсүрэн гишүүний ярьж байгаа зүйлтэй яг санал нэг байгаа. Тэгээд өнөөдрийн эрх зүйн орчин энийг чинь зохицуулаагүй эсхүл нэн хангалтгүй зохицуулаад явж байгаа учраас яг таны ярьж байгаа проблемууд гарч байгаа юм. Жишээлбэл нохой буудах хүн Монголд олдохгүй шүү, цаашидаа ч олдохгүй. Тэгэхээр энэ дээр чинь юу хийж байна гэхлээр 5 жилд энэ цонхыг нь

гаргаж өгөөд энэ буудах ажиллагаанууд бол яалт ч үгүй бид нар ч ажлын хэсэг дээрээ ярьж байгаад буудах дуртай нэг ч хүн байхгүй. Гэхдээ өөр сонголт байхгүй учраас энэ цаашиа үргэлжлээд явна. Гэхдээ 5 жилдээ энэ хуулийн дагуу ямар мессеж очиж байна гэхээр энэ нийслэл, аймаг, дүүргийн Засаг даргын түвшиндээ бодлогоо зохицуулаад эндээ бэлд. Цаашидаа устгал явна шүү дээ. Тэрийгээ бол харин 5 жилийн дараа бол унтуулах, тэгээд тэрэндээ тохирсон бүтцийн өөрчлөлт тэр юу төсөв бүх юмаа зохицуулах ёстой. Тэгэх юм бол буудахгүйгээр унтуулах юун дээр бол хүмүүс өнөөдрийн таны ярьж байгаа олдохгүй шүү дээ, энэ хэцүү гэдэг асуудал байхгүй болно шүү дээ.

Тэгэхээр энэндээ системээ зохицуулах л тухай асуудал. Энэ эзэнгүй амьтдын байр нөгөө сууцын тухай асуудал гэвэл ерөөсөө өнөөдөр энэ нийгэм чинь өөрөө хөгжчихөөд ийм байгууллагууд чинь явж байгаа байхгүй юу. Тэгээд өөрсдөө мөнгөө босгоод, сэтгэлээрээ хийж байгаа юмнууд байгаа. Гэхдээ эрх зүйн орчингүй. Тэрийг нь эрх зүйн орчинтой болгож өгч байгаа байхгүй юу.

Л.Мөнхбаатар: Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. 60,5 хувиар санал дэмжигдлээ.

40.Төслийн 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсгийн “шагнал” гэсний өмнө “сугалаа” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энэ шигтгэсэн хувилбарыг нь надад аваад ирээч. Энэ зарим энэ үг үсэг, найруулга нь жаахан юутай л байгаад байх шиг байна. 55,8 хувиар санал дэмжигдлээ. За яах вэ юу яачихъя, нааш нь өгчих.

41.Төслийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсгийн “Иргэний хууль,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60,5 хувиар санал дэмжигдлээ.

42.Төслийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“52.1.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60,5 хувиар санал дэмжигдлээ.

43.Төсөлд доор дурдсан агуулгатай 52.2 дахь хэсэг нэмэх:

“52.2.Энэ хуулийн 12.4 дэх хэсгийг Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг хэрэглэх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан хугацаанаас хойш мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн хэрэглэх журмын тухай хууль гэж байгаа юм байна шүү дээ тийм үү? 51,2 хувиар санал дэмжигдлээ.

44.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.12 дахь заалт нэмэх: 3.1.2, 3.1.2 биш энэ 3.1.12 уу тийм ээ, техникийн алдаа байх байна шүү, энийгээ нэгийн тоог нэмээрэй.

“3.1.12. “нохойны удмын бичиг” гэж олон улсын байгууллагын албан ёсны гишүүн байгууллагаас олгодог тухайн нохойны гарал үүсэл, эцэг, эх, төрөлт, төрсөн огноо, хүйс, үүлдэр зэргийг заасан баримт бичгийг.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан. Туваан гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал байна. Санал хураалт. 53,5 хувиар санал дэмжигдлээ. 15 дугаар зүйлд.

45.Төслийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.4.6 дахь заалт нэмэх:

“15.4.6.цэвэр үүлдрийн нохойны хувьд удмын бичиг.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан. 60,5 хувиар санал дэмжигдлээ. Туваан гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй 2 санал дэмжигдлээ.

46.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар, эшлэлийг нийцүүлэн өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 60,5 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал. 1.Төслийн 3.1.7 “энэ хуульд заасан журмын дагуу” гэснийг “энэ хуульд заасны дагуу”, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт “зүйлийн 18.1-т заасан эхний” гэснийг “хуулийн 18.1-т заасан бүртгэлийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 53,5 хувиар санал дэмжигдлээ.

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дэмжсэн саналууд байна.

Нэг.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Нохой, эсхүл мууранд “гэснийг “Гэрийн тэжээвэр амьтны асран хамгаалагч, түр харагчийн нохой, мууранд” гэж өөрчилж, “бусад” гэсний дараах “гэрийн тэжээвэр амьтны асран хамгаалагч, түр харагчийн” гэснийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Т.Аубакир, Э.Батишугар, Г.Дамдинням, Ц.Туваан. Ажлын хэсэг. Санал хураалт гишүүдээ. 55,8 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “нэг нохой, эсхүл мууранд” гэснийг “нохой, муур тус бүрд бичил” гэж өөрчилж, мөн зүйлийн 11 дэх хэсгийн “шагнал” гэсний өмнө “сугалаа,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 53,5 хувиар санал дэмжигдлээ.

Хоёр.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал хураалтыг явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5 дугаар зүйлийн “5.1.55” гэснийг “5.1.57” гэж, “17 дугаар зүйлд” гэснийг “14 дүгээр зүйлд” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 21 дүгээр зүйлийн “21.1.38” гэснийг “21.1.48” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 55,8 хувиар санал дэмжигдлээ.

Гурав.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “6.10 дахь” гэснийг “6.44 дэх” гэж, “7.17” гэснийг “6.15” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 51,2 хувиар санал дэмжигдлээ.

Дөрөв.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “бүртгээж эрхэлнэ.” гэснийг “бүртгээж эхэлнэ.” гэж өөрчлөх, төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.4-д заасны дагуу нохой, муурын бүртгэлийн сан бүрдүүлэх, бүртгэл хөтлөх журмыг энэхүү хууль хүчин төгөлдөр болсноос хойш 6 сарын дотор баталж, нохой, муурын бүртгэлийн системийг нэг жилийн дотор хөгжүүлж, ашиглалтад оруулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Санал хураалт гишүүдээ. 54,8 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн “Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан” гэснийг “Гэрийн тэжээвэр

амьтны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 51,2 хувиар санал дэмжигдлээ.

3.Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөлд доор дурдсан агуулгатай 9 дүгээр зүйл нэмэх:

“9 дүгээр зүйл.Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль хүчин төгөлдөр мөрдөхөөс өмнө үржил хязгаарлах мэс ажилбар хийлгээгүй найм болон түүнээс дээш настай нохой, муурын асран хамгаалагчид Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.3 дахь заалт хамаарахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. 60,5 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр БОХХАА-н байнгын хороонд шилжүүлээ.

11.13 цаг

Үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөж байна. Үдээс хойших хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг хэлэлцэнэ. Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийн агуулга нь Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шинэтгэлийн бодлогын талаар Ерөнхий сайдын мэдээллийг сонсоно.

2023 оны 11 дүгээр сарын 17, Баасан гараг,
Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 05 минут.

**ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Л.Мөнхбаатар: Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаан эхэлснийг мэдэгдье.

Хоёр.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шинэтгэлийн бодлогын талаар/

Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг хэлэлцэнэ. Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шинэтгэлийн бодлогын талаар ХЗДХ-ийн сайд Баттөмөрийн Энхбаяр мэдээлэл хийнэ. Таныг индэрт урьж байна.

Б.Энхбаяр: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Өнөөдөр манай улсад хүний эрхийн хамгийн гол дайсан авлига болоод байна. Авлига ард иргэдийн сайн сайхан амьдралын боломжийг хулгайлж байна. Байгалийн баялаг, нийтийн эзэмшлийн газар, зам талбай, сургууль цэцэрлэгээс эхлээд авлигачдын гар хүрээгүй салбар алга. Тийм ч учраас Монгол Улсын хөгжлийг боомилон сааруулагч гол хүчин зүйлс болох авлига, албан тушаалын гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөлийг арилгаж, бүх шатанд авлигатай тэмцэн хүний эрхийг хангаж, нийтийн эрх ашгийг хамгаалах зорилгоор ЗГ-аас 2023-аас 2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарласан бөгөөд хууль, эрх зүйн шинэчлэлийг эрчимжүүлж төрийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод болгон, иргэд олон нийтийн оролцоо хяналт тавих боломжийг өргөжүүлэх зорилт тавин ажиллаж байна. Энэхүү зорилтын хүрээнд бид нэн тэргүүнд авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах, өршөөл үзүүлэхгүй байх өөрчлөлтийг Эрүүгийн хуульд оруулах хуулийн төслийг санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн

мэдүүлсэн нь 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдөр батлагдан хэрэгжиж эхэлсэн.

Мөн эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, хээл хахууль авах, үндэслэлгүй хөрөнгөжих, гэмт хэрэг үйлдсэн улс төрд нөлөө бүхий этгээдийг хорих ялаас хугацаанаас өмнө суллахгүй байхаар оруулсан Эрүүгийн хуулийн өөрчлөлт Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар эцэслэн батлагдахад бэлэн болоод байна. Авлигатай тэмцэх гол арга замын нэг бол төрийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдал бөгөөд энэ хүрээнд Улсын Их Хурлаас Бүртгэлийн багц хууль, Цахимын багц хууль болох Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүнийг хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хуулийг шинэчилсэн найруулгыг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр баталж, эдгээр хуулийн хэрэгжилтийг зохион байгуулан амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.

Үүний үр дүнд Монгол Улс НҮБ-аас гаргадаг цахим засаглалын индексээр 18 байраар урагшилж чаджээ. Бизнес эрхлэгчдийг дэмжих, хөрөнгө оруулалтыг татах, эрх ашгийг хамгаалах үүднээс хууль тогтоомжийн төсөл боловсруулахад ил тод, нээлттэй байдлыг хангах, тэдний оролцоог хангах, батлагдсан хууль тогтоомжийг сурталчлах, мэдээллээр хангахад чиглэсэн өөрчлөлтүүдийг Хууль тогтоомжийн тухай хуульд тусган хэрэгжүүлж байна. Улсын Их Хурлаас 2016 онд баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжих хугацаа 2023 онд дуусаж байгаатай холбогдуулан авлигатай тэмцэх цогц арга хэмжээг агуулсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг шинээр баталсан бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг энэ чуулганаар батлуулахаар ЗГ-аас боловсруулж байна.

Нийтийн эрх ашгийн төлөө авлига, албан тушаалын гэмт хэргийн талаар мэдээлж байгаа шүгэл үлээгчийг

хамгаалах, урамиуулах, Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг ЗГ-аас санаачлан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна. Эрдэнэт үйлдвэр, ЭТТ, Тавантолгой болон бусад ТӨК-д шургалсан хулгай луйврын гол шалтгаан нь муу засаглал, нээлттэй бөгөөд ил тод бус олон нийтийн хяналт сул байгаатай холбоотой юм. Иймд төрийн болон орон нутгийн өмч, түүний хяналтыг сайжруулах, чөлөөт өрсөлдөөнийг зах зээлийн зарчмаар нь явагдах боломжийг бүрдүүлэх, компанийн засаглалыг дээшлүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх, төрийн өмчийн хяналтыг хэрэгжүүлэх, төр, бизнес эрхэлж хувийн хэвшилтэй өрсөлдөхгүй байх, өндөр зардлаар ТӨК-ийг ажиллуулахгүй байх эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байна. Хаана төрийн өмч байна тэнд хулгай тасрахгүй байна. Хяналтгүй, эзэнгүй төрийн өмчийн менежментийг сайжруулж байж төрийн өмчийг өөрийн хувийн өмч мэт зарцуулдаг түшмэдээсээ салж байж бид авлигыг ялах болно.

Монгол Улсын экспортын 93 хувь нь уул уурхайн салбар бөгөөд энэ салбарыг ил тод болгох нь авлигын эсрэг тэмцлийн гол зорилт юм. ОУБ-аас хийсэн авлигын судалгаагаар манай улсын эрдэс баялгийн буюу ашигт малтмал газрын тосны салбар нь авлигад өртдөгөөрөө хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Иймд ЗГ-аас Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр төлөвлөж байна.

Эрхэм гишүүд ээ, ЗГ-аас авлигатай тэмцэх үйл ажиллагааг манлайлж 5Ш ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд тухайлбал үйл ажиллагааны хүрээнд ажлын хэсэг баасан гараг бүрийн 9-өөс 12 цагт ЗГ-ын иргэд олон нийттэй харилцах 11 11 төвд ажиллаж, иргэдтэй уулзан, утсаар

мэдээлэл авч байна. Өнөөдрийн байдлаар мянга орчим иргэн санал, хүсэлт, гомдлыг холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлж, гомдол мэдээлэл, дүн шинжилгээ хийн, иргэд, хувийн хэвшлийг чирэгдүүлж, хүнд суртал гарган, авлига үүсгэх нөхцөл бүрдүүлж байж болзошгүй салбар байгууллагуудад шуурхай арга хэмжээ авч ажилласан. Шүүр ажиллагааны хүрээнд төрийн алба, төрийн өмчийг шимэгчдээс салгах шүүр ажиллагааны хүрээнд төрийн албан хаагчийн хууль бус томилгооны талаарх мэдээллийг холбогдох сувгаар хүлээн авч зөрчлийг илрүүлэх ажиллагааг хийж байна.

Шүүр ажиллагааны үр дүнд 3387 байгууллагын 3159 албан тушаалтанд хамаарах нийт 6278 зөрчлийг илрүүлсэн бөгөөд үүнээс 1334 албан тушаалтанд мэдэгдэл хүргүүлж, 481 албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлж бусад 1344 албан тушаалтны зөрчлийг арилгуулах арга хэмжээг зохион байгууллаа. Түүнчлэн төрийн албан хаагчийн хууль бус томилгоотой холбоотойгоор Shuur.gov.mn цахим хуудсанд 1050 гомдол мэдээллийг хүлээн авсан бөгөөд үүний 353 нь төрийн байгууллага, ТӨК дахь хууль бус томилгоо, 304 нь хууль, албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжлийн болон мэргэжлийн ур чадварын шаардлага хангаагүй, 184 нь төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм хэм хэмжээг зөрчсөн этгээдийг албан тушаалд томилсон мэдээлэл эзэлж, үлдсэн нь бусад хууль бус томилгооны талаарх мэдээлэл байна.

Шувуу ажиллагааны хүрээнд Интерпол болон олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллагын улаан булант зар мэдээгээр 22, хөх булант зар мэдээгээр 70, нийтдээ 92 этгээд эрэн сурвалжлагдаж байсан бол 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн байдлаар Интерполын улаан буланд зар мэдээгээр 4, хөх буланд зар мэдээгээр 50, нийт 54 этгээдийг олж тогтоосон. Үүнээс

мөрдөн шалгах байгууллагаас олж тогтоож Монгол Улсад авчирсан 11, сайн дураараа хэргээ шийдвэрлүүлэхээр ирсэн 14, нийтдээ 25 этгээдэд холбогдох хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна. Интерполын шугамаар эрэн сурвалжлагдаж байгаа үлдсэн 38 этгээдээс байгаа газар нь тогтоогдсон 24 этгээд байна. Интерполын улаан буланд зар мэдээгээр эрэн сурвалжлагдаж байгаа нийт 10 этгээдийг шилжүүлэн авахаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ болон хамтын ажиллагааны тухай харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд тухайн улсын хууль сахиулах байгууллагад албан бичиг хүргүүлж, хамтран ажиллаж байгаа бөгөөд цаашид оршин суугаа улс нь тогтоогдоогүй 14 этгээдийг эрэн сурвалжлах ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна. Шилжүүлэн авах ажиллагааны хүрээнд авлигын гэмт хэргийн хохирлыг барагдуулах хүрээнд 2023 оны 9 дүгээр сарын байдлаар 131,8 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлээд байна. Үүнээс гадаад улсаас Монгол Улсад 12,2 сая ам.долларын хөрөнгийг буцаан авчраад байна.

Шил ажиллагааны гол цөм бол Нийтийн мэдээллийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах асуудал юм. Уг ажлын хүрээнд нээлттэй мэдээллийн нэгдсэн систем, shilen.gov.mn цахим системийг ашиглалтад оруулж, үндэсний хэмжээнд шилэн индексийг зарлан, иргэд, олон нийтийг нээлттэй мэдээллээр ханган ажиллалаа. Түүнчлэн яам, агентлаг, аймаг, нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 123 төрийн болон төрийн өмчит өмчийн оролцоотой мэдээлэл, харилцагч байгууллагатай холбогдож, info.shilen.gov.mn цахим шуудангаар 550 гаруй багц мэдээллийг хүлээн авч системд байршуулаад байна. Шил ажиллагааны системийг 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөр ашиглалтад оруулснаас хойш өнөөдрийн байдлаар нийтдээ 39 төрлийн 970355 мэдээллийг байршуулж нийтдээ 5,4 сая хандалт аваад байна.

Авлигатай тэмцэх нь зөвхөн төрийн хийх ажил биш, бүх нийтийн үйл хэрэг бөгөөд авлигатай тэмцэх үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн бодит оролцоо үр дүнтэй хяналтыг бэхжүүлэхэд онцгой анхаарах ёстой. Энэ ч утгаар авлигатай тэмцэх ажлыг иргэн, иргэний нийгмийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх чиглэлийг баримталж, энэ талаар бодлогын баримт бичиг, хууль тогтоомжид бататган бэхжүүлж байна.

Авлигатай тэмцэхэд парламентын улс төрийн манлайлал онцгой ач холбогдолтой гэдгийг зориуд тэмдэглэж байна. Занданшатар даргатай Улсын Их Хурлаас Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг санаачлан баталж, энэ оны эхээр Хөгжлийн банкны сонсголыг амжилттай зохион байгуулсан бол одоо ирэх сард нүүрсний хулгайтай холбоотой нотлох баримтыг шинжлэн судлах сонсголыг хийх гэж байна. Үүний үр дүнд дампуурах шахсан Хөгжлийн банк өнөөдөр санхүүгийн хувьд хөл дээрээ бат зогсож, саяхан өөрийн хөрөнгөөр 500 сая ам.долларын бондын төлбөрөө барагдууллаа. Мөн түүнчлэн авлигатай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийн үр дүнд эдийн засаг тогтворжин төсвийн тэнцэл ашигтай гарч, цалин хөлс тэтгэвэр нэмэгдэх боломж бүрдсэн бөгөөд ганцхан жилийн өмнө 2,5 тэрбум ам.доллар байсан валютын нөөц 4,1 тэрбум ам.доллар болж нэмэгдээд байна. Эндээс иргэдэд шууд хүрсэн гол үр дүн бол цалин, тэтгэврийн нэмэгдэл юм. Тэтгэврийн доод хэмжээг 500 мянган төгрөг болгож мөн үүн дээр энэ зун 1 их наяд төгрөг зарцуулж, нийт ахмадуудын авч буй тэтгэврийг 10 хувиар нэмэгдүүлэхээр боллоо. Түүнчлэн ЗГ 2023 оны 5 дугаар сард Гэрээг бондын өрийн үлдэгдэл 368,7 сая ам.долларыг бүрэн төлж барагдуулсан нь 2021 онд Кредит Свисс банкны 60 сая ам.доллар, Мазаалай

бондын 136,8 сая ам.доллар, 2002 онд Чингис бондын 136,8 сая ам.долларын өрийг төлж барагдуулсан нь ЗГ-ын бодлогын үргэлжлэл болж байна.

Оюун-Эрдэнийн тэргүүлсэн ЗГ өнгөрсөн хугацаанд нийтдээ 5,9 их наяд төгрөгийн өр төлбөрийг бүрэн төлж барагдуулснаар 2020 оны эцэст ДНБ-ий 62,3 хувьд хүрээд байсан өрийн дарамт 44,3 хувьд хүрч буурсан байна.

Эрхэм гишүүд ээ, авлигыг өөгшүүлж буй нэг хүчин зүйл нь иргэнд биш даргад хяналтгүй эрх олгосон хууль журам юм. Шударга ёсыг нэхэж буй ард иргэдтэйгээ ЗГ хамт байна. Авлигыг таслан зогсоож, хариуцлага нэхсэн ард түмний шаардлагыг ЗГ дэмжиж ажиллах болно. Харин иргэдийн авлигыг жигшиж буй чин хүсэл, дарга нарын дураараа аашилдаг байдлыг таслан зогсоох хүсэл дээр ашиг хонжоо гаргаж, авлига, хулгайгаа нуух, хариуцлагаас зугтах, иргэдийн чөлөөт үзэл бодлыг төөрөгдүүлэх санаачлахыг дэмжихгүй бөгөөд эвлэрэхгүй. Та бид удахгүй нүүрсний хулгайтай холбоотой сонсголыг парламент дээрээ нээлттэй хийх гэж байна. Монголын ард түмний өмч болох байгалийн асар их баялгаас хулгайлсан авлигачдын үнэн нүүр царай энэ үеэр ил болно. Авлигачид зовлон дээрээ нэгдэж байна. Тийм ч учраас авлигачдын ард түмний хилэн, шударга үнэнээс айж нэгдсэн зохион байгуулалтад орж олны анхаарлыг сарниулан, нийгмийн тогтворгүй байдалд хүрэх замаар сонсголыг зогсоох тасалдуулахыг санаархаж байна. Монголын ард түмэн авлигын эсрэг тэмцэлд ялах болно. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Энхбаяр сайдад баярлалаа. Мэдээлэлтэй холбогдуулан цөөнхийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дахь АН-ын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл үг хэлнэ. Таныг индэрт урьж байна.

О.Цогтгэрэл: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Та бид өнгөрсөн 7 жилд бид бүр, бид өдөр бүр авлигачдыг дарах тухай, авлигыг багасгах тухай дасал болтлоо сонссон. Монголын төр бүх шатандаа авлигажиж авлигын ангал руу улам бүүр унасныг, авлига нийгмийн бүх салбарт нэвчин цэвэрлэх аргагүй болсон тухай, авлига улс орны хөгжлийг боомилж, Монгол хүн бүрийг хохироож буй тухай, өнөөгийн манай нийгмийн хамгийн том асуудал болох ядуурал, гэмт хэргийн өсөлт, утаа, түгжрэл, хүн амын өвчлөл, өр зэрэг, өр гээд асуудлын эх үүсвэр нь бүгд авлига болох тухай ярьж ирснийг мэднэ. Авлигаас ангижрахгүйгээр юуг ч өөрчилж, юуг ч шинэчилж чадахгүй нь тодорхой.

Гэхдээ гэвч 60 тэрбумын хэрэг, ЖДҮ-ийн хэрэг, Хөгжлийн банкны хэрэг, төмөр замын хэрэг, ковидын асуудал, ковидын сонсголын үеийн асуудал, нүүрсний хэргүүд, улаан ногоон, дан, давхар автобусны гээд авлигын хэргүүдийн нэршил он цагийн тоолол шиг үргэлжилсэн хэвээр л байна. Авлигын дүн аль хэдийн 13 тэгтэй тоогоор илэрхийлэгдэх боллоо. Гэсэн ч одоог хүртэл авлигачид нь олдоогүй байна, хэн ч хариуцлага хүлээгээгүй. Хамгийн аймшигтай нь ЗГ авлига үүсээд байгаа учир шалтгааныг олоогүй аль эсвэл мэдэж байгаа ч арилгах хүсэлгүй байна. Жил бүр 30 гаруй хувиар төсөв тэлж, даргын гарын үсгээр шийдэгддэг мөнгө өсөж байхад авлига буурахгүй. Авлигыг бууруулах арга нь ард иргэд бизнесийнхэндээ орон зайг нь олгож, тэлсэн том төсвөө цомхотгох явдал юм. Төрийг томруулчихаад авлигатай тэмцэнэ гэдэг нь зүгээр л хууран мэхлэлт юм.

Авлигын индекс буурч байна гэдэг нь улам авлигажиж байгааг л илэрхийлдэг. Уг мэдэгдэлд 21 онд 35 оноо авч байсан бол 22 онд 33 оноо авч анх удаа буур буурсан гэжээ. Гэтэл 21 оноос 180, 21 онд 180 орноос 110-д байсан болбол 22

онд 116-д болж хойшилж. Уг нь 2014, 2015 онуудад 39 оноо авч бид нар 72-т орж байлаа. Сүүлийн 7 жилд 2 оронтой тоо руу 30, 40 байраар авлига ихэссэнийг илтгэж хойшиллоо. Дүгнэж хэлбэл, Монгол Улс сүүлийн 8 жилийн хугацаанд авлигадаа гүн идэгдэж, Бразил, Тайландтай ойролцоо байсан бол одоо Африкийн Алжир, Ангол гээд орнуудтай авлигаараа зэрэгцэж очлоо. Авлига гэдгийг хүн төрөлхтөн ойлгохдоо тэр тусмаа авлигын индекс гаргадаг Транспаренси интернэйшнл зэрэг байгууллагууд тодорхойлохдоо зөвхөн төрд байгаа авлигын хэмжээг, авлигыг хэмждэг ийм тогтсон ойлголттой. Гэтэл уг мэдээлэлд, ирсэн мэдээлэлд хувийн хэвшлийн авлигыг бууруулна гэж гэж зааж өгсөн, гэж гэсэн нь заагаад өгсөн байг өөрчлөх гэсэн оролдлого гэхээс өөр бас аргагүй. Төрд байгаа, Монголд төрийн үүсгэж байгаа хүнд суртал, авлигын хувь авлигыг хувийн хэвшилд нялзаах нь утгагүй ийм оролдлого. ОУБ-аас гаргадаг глобал авлигын барометрийн судалгаагаар Монголчуудын 69 хувь нь авлига хамгийн том асуудал гэж хариулжээ. Авлигыг гааруулж буй шалтгаан нь жил бүр өсөн нэмэгдэж байгаа улсын төсөв, эдийн засагт ноёлох нөлөө үзүүлэх болсон төрийн өмчийн компаниуд, төрөөс олгодог эх захгүй зөвшөөрөл бас хэт данхайсан төрийн албаны хүнд суртал, төрийн захиргааны болон удирдах ажилтны хуулийг уландаа гишгэсэн явдлууд, авлигын хэрэг нь нотлогдсон хүн зохих шийтгэл хүлээдэггүй ийм байдал юм.

2022 оны 10 дугаар сарын 12-нд Ерөнхий сайд Оюун-Эрдэнэтэй олон улсын авлигын индекс гаргадаг байгууллагынхан нь уулзахдаа Монгол Улсад авлигыг бууруулахад Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулиа батлаач, ТӨК-удынхаа засаглал ил тод байдлыг сайжруулахад арга хэмжээ аваач. 3 дугаарт нь Хүний эрх хамгаалагчдын эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэх зэрэг ажлууд чухал байгаа талаар саналаа

хэлж байжээ. Эрдэс баялгийн салбар хамгийн их авлигажчихаад байгааг зөвхөн олон улсын байгууллагуудад хэлээд байгаа төдийгүй Монголын хамгийн том авлигын жишиг 40 их наядын нүүрсний хулгай нотлон харуулдаг. Гэтэл өнөөг хүртэл бүтэн жилийн хугацаанд Олборлох салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн бариагүй байгаа нь авлигатай тэмцэх хүсэл зориг дутагдаж байгаагийн илэрхийлэл.

Түүгээр ч зогсохгүй өнгөрсөн хугацаанд ТӨК-удын засаглалыг сайжруулах биш, харин ч бүрэн эрхт төлөөлөгч томилж хуулиас гадуур, дураар авлигажих нөхцөлийг бүрдүүлж ирснийг яг юу гэж ойлгох юм бэ? Хүний эрх хамгаалагчдын эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээг яагаад хийхгүй байна вэ? Холын зорилго үгүй аваас ойрын зовлон салахгүй гээд үг бий. Ийм ч учраас авлигагүй улс орон болох, авлига үүсдэггүй нөхцөлтэй системийг бий болгоход зорихгүй бол сонгуулиас сонгуулийн хооронд бүлэг фракцууд нам хоорондын зодооны хэрэгсэл, PR-н багаж зэвсэг төдийхнөөр соёл уламжлал болтлоо бэхэжсэн авлигыг бид ялж өөрчилж чадахгүй. Авлигатай тэмцэх ажил бол сөрөг хүчнийхнийг хэвлэлээрээ ялалдаг, эрх баригчид бие биеэ түр саатуулаад сулладаг, хөөн хэлэлцэх хугацаагаар нь ялаас мулталдаг арга барилаар тэмцдэг зүйл биш. Эрх баригчдын ангийн андууд, намын нөхдөө нэг барьж, нэг тавьж төөрдөг спорт загасчлал бол бас бүүр ч биш.

ЗГ-т авлига хулгайтай тэмцэх хүсэл зориг байдаг бол алга ташуулахын тулд хийж буй авлигач хулгайчтай тэмцсэн дүр үзүүлж буй шувуунаасаа урьтан авлига хулгай үүсэж буй нөхцөл байдалтай нь тэмцэж, зөв системийг бий болгоход болгох чиглэлд ажлаа эрчимжүүлэхээс эхлэх ёстойг АН-ын бүлгийн зүгээс бас ахин сануулан хэлье.

ЗГ 2023 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлаж 5Ш ажиллагаа гэгч

уран зохиолын хэллэгтэй, сүржин нэртэй суртал ухуулгын ажлыг зарлаж, ганц нэг хүний гавтай зураг тавьснаас өөрөөр авлигыг бууруулах бодит ажил хийгдсэнгүй. 2012 онд АН-ын ЗГ-ын үед санаачилсан 11 11 гээд шуурхай утсыг сэргээн ажиллуулсныг шүгэл ажиллагаа гэж, интерполын зарын буланд эрэн сурвалжилж байгаа хүмүүсийн мэдээллийг оруулсныгаа шувуу ажиллагаа гэж нэрлэжээ. Шилжүүлэн авах ажиллагаа гэдэг нэрийн доор ганц нэг хүнийг гадаадаас авчирч байгаа зураг тавьснаас бас хэтэрсэнгүй. Шүүр ажиллагааны хүрээнд ковидын нэр барьж төрийн албаны шалгалтгүйгээр ажилд авсан албан тушаалтнуудыг чөлөөлж. Харамсалтай нь үүнд цар тахлын үед хүнд ачаа үүрүүлэхээр авч ажиллуулсан эрүүл мэндийн салбарын чадварлаг ажилтнуудаас хоморголон халжээ. Шилэн ажиллагаа гэдгийн хүрээнд веб сайтад зочилсон зэрэг статистик мэдээллээс өөр хэлэх зүйл олдохгүй байгаа нь илт байна тайлангаас харахад. Иргэдэд хэдэн хүн веб сайтаар зочилсон нь чухал биш, нууцад хамруулсан нүүрсний, автобусны гэрээ, хөнгөлөлттэй зээлийн сангуудын мөнгийг хэнд, ямар нөхцөлөөр олгосон нь илүү сонин байх ёстой байх иргэдэд.

АН-ын бүлгийн зүгээс авлигатай тэмцэх тэмцлийг үр дүнтэй болгохын тулд дараах арга хэмжээг бас нэн яаралтай авах ёстой гэж үздэг. Эрх зүйн орчны шинэчлэлийн хүрээнд. Эрүүгийн хуульд авлигын хэргийг үндэсний аюулгүй байдлын зэрэг, байдлын хэрэгтэй адилхан үзэж хөөн хэлэлцэх хугацаагүй болгох асуудлыг бид нар тусгах шаардлагатай. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийг нэн яаралтай боловсруулж, Улсын Их Хурлаар хэлэлцэн батлах шаардлагатай байна. Төрийн болон орон нутгийн өмчит ААН-ийн хуулийг шинэчилж, бизнесийн байгууллагуудтай өрсөлддөг байдлыг эрх зүйн хүрээнд таслан зогсоох шаардлагатай байна. Зөвшөөрлийн хуулиа бас өөрчилж, төрөөс олгодог зөвшөөрлийн тоог дахин эрс

бууруулах, зайлигүйгээс бусад зөвшөөрлүүдийг дахин цуцлах шаардлагатай байна.

Зохион байгуулалтын хүрээнд. Энэ тэлж буй төсвийг хумих чиглэлд анхаарах шаардлагатай. Энэ дээр тодорхой бодлогын тоон үр дүнгүүд гаргах хэрэгтэй байна. ТӨК-удыг олон нийтийн болгон өөрчлөх төлөвлөгөөг тодорхой болгож үе шат, үе шаттайгаар хувьчлах, нээлттэй болгох асуудлуудыг шийдвэрлэх хэрэгтэй байна. Төрийн хяналт шалгалтын давхардлыг бууруулах, хялбаршуулах арга хэмжээ авах шаардлагатай байна. Төрийн захиргааны бүх албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлэгт шинжилгээ хийж, эх үүсвэр нь тодорхойгүй орлого дээр бас анхаарал хандуулах шаардлагатай байна. Төрийн захиргааны бүх байгууллага, төрийн өмчит ААН-үүдийн удирдлага иргэний нийгмийн байгууллагуудын нээлттэй мэдээллийг гаргаж өгөхөөс татгалзсан тохиолдолд ажлаас нь чөлөөлөх хүртэлх үндэслэл болгодог энэ журам дүрмийг бий болгон ажиллах бас шаардлагатай байна гэж үзэж байна. Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Одонгийн Цогтгэрэл даргад баярлалаа. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. ХЗДХ-ийн сайд Баттөмөрийн Энхбаяр, ХЗДХ-ийн Дэд сайд Баярсайханы Солонгоо, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Жаргалцэнгэлийн Эрхэмбаатар, ЗГХЭГ-ын дэд дарга бөгөөд ЗГ-ын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Барсүрэнгийн Баасандорж, ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх газрын Хяналт шалгалтын газрын ахлах хянан шалгагч Төмөрбаатарын Нармандах, ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ганзоригийн Эрдэнэбулган, ХЗДХЯ-ны Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Нармандахын Жамъянхүү, ХЗДХЯ-ны Хууль зүйн

бодлогын газрын ахлах шинжээч Шагдарсүрэнгийн Цолмон, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Бадамдоржийн Билэгдэмбэрэл, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим засаглалын хэлтсийн дарга Баатарчулууны Золбоо, ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн албаны дарга Энхээгийн Сэргэлэнбаатар, ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн албаны Эрэн сурвалжлах хэлтсийн дарга Даихүүгийн Очгэрэл, АТГ-ын газрын Мөрдөн шалгах хэлтсийн Албаны дарга Чимэддоржийн Жаргалбаатар, АТГ-ын Гүйцэтгэх ажлын хэлтсийн Албаны дарга Төмөрийн Хатантөмөр. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Лхамтүмэдийн Нямгэрэл нар оролцож байна.

Мэдээлэлтэй холбогдуулан ХЗДХ-ийн сайд болон ажлын хэсгийн гишүүдээс асуулт асууж, үг хэлэх цөөнхийн гишүүд байна уу? Нэрсээ өгье. Цэвэгдоржийн Туваан гишүүнээр тасаллаа. Зөвхөн цөөнхөөс асууна. Дуламдоржийн Тогтохсүрэнгийн даргыг хасъя. Энэ чинь олонхын бүлгийн дарга яагаад цөөнхийг нь төлөөлж үг хэлэх гээд байна. 3 гишүүнээр ингээд тасаллаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Ялын бодлогыг хэчнээн чангаруулаач, авлигын эсрэг янз янзын хууль баталлаа ч авлига буурахгүй байгаагийн үндсэн шалтгаан бол дээрээ хүмүүс нь 7 жилийн туршид олон, олон янз бүрийн бүүр тоогоо алдсан хэмжээний хулгайд холбогдсонтой л холбоотой л доо. Дээд дарга нар ингээж хулгайлж байгаа юм чинь бид нар ч гэсэн бас яадаг юм гэдэг байдалтай бүүр асуудалд ханддаг болсон. Сүүлийн үед дунд шатын, ер нь дээрээ ч гэсэн бас байгаа, доод шатын албан тушаалтнууд яаж байна гэхээр төрийн албан хаагч нар энэ ийм их муу нэр хүндтэй байгаа юм чинь энэ МАН ялагдах юм байна. Тийм учраас бушуухан шиг байгаа дээрээ идэж

уугаад авъя гэдэг ийм хандлага бол засаг замбараагүй болсон.

Ганцхан нүүрсний хулгай гэхэд л 29-хөн километр газар 120 сая төгрөгөөр тээвэр хийдэг, 3 сая төгрөгөөр тээвэр хийдэг байсан шүү дээ. Тэрийг 120 сая төгрөгөөр тээвэр хийгээд л тэгээд л хулгайлаад байсан. Тэгээд өнөөдөр тэр нь 20 сая болчихсон байна. Тэрнээс ч багасах ёстой. Тэнд бас авлигал хээл хахууль явж л байна гэсэн үг. С зөвшөөрлийн өртөг тэн дотор орчихсон гэсэн үг, 20 сая төгрөг болчихсон шүү дээ. 1 С зөвшөөрөл улиралд авахад. 16 онд зүгээр нэг цаас байсан юм. Тэгээд энэ нүүрсний хулгайтай тэмцээний үр дүнд яах вэ тэнд чинь нүүрсний хулгайч нар яасан бэ гэхээр аль болох хэмжээ дамжааг нь багасгаж байгаад, оочир дараалал бий болгож байгаад тэндээ авлигал хээл хахууль бий болгож, 120 сая төгрөгөөр тээвэр хийдэг байсан байхгүй юу. Яах вэ хулгайтай тэмцээний, нүүрсний хулгайтай тэмцээний үр дүнд өнөөдөр нүүрсний экспорт 9 сарын дундуур 350 мянган тонн хүрч рекорд тогтоолоо л доо. Тэгээд нөгөө нэг амнаас нь 60 доллароор 600 доллар байж байхад амнаас нь 60 доллароор зараад байдаг байсан тэр нүүрсний үнэ нь өсөөд 175 доллар болчихсон байж байгаа. Үүний үр дүнд, зөвхөн нүүрсний хулгайтай тэмцээний үр дүнд хагас жилийн төсвийн орлого 23 хувиар давуулан биелэгдэж байна шүү дээ. Тийм учраас энэ авлигал хээл хахууль бол үнэхээр Монголыг хөгжлийг хойш нь татаж байгаа.

Тэгээд өнөөдөр замбараагүй боллоо, одоо тэгээд л ЖДҮ, Хөгжлийн банк, концесс, оффтейк гэрээ, нүүрсний хулгай, төмөр замын хулгай, ногоон автобус, боловсролын зээлийн сан энэ тэр гээд. Бүх дээрээ ингээд бүгдээрээ ингээд янз янзын асуудалд холбогдчихсон тэр хүмүүс нэгэндээ барьцаалагдсан тэр хүмүүс нэгэндээ үг хэлэхээ чадахаа больсон. Тэгэнгүүт хариуцлага тооцохгүй болохоор доод талын бүх шатын албан тушаалтнууд чинь дээрээ ингээж байгаа

юм чинь бид нар ч гэсэн идээж ууна гэдэг ийм байдлаар хандаад ерөөсөө энэ Монголын хөгжлийг хойш нь татаж байгаа ганц зүйл тэр л болчхоод байна. Тийм учраас ялын бодлогыг чинь энэ Их Хурал бол хангалттай чангалаад өгчихсөн байгаа. Тэр асуудал гаргасан тэр хүмүүсээ оруулж ирээд шийтгэхийг нь шийтгээд ингээд явмаар байна. Би нэг зүйл хэлж байгаа шүү дээ. Одоо та бүхэнд бүх эрх мэдэл байж байна. Тэр АН-ын асуудал гаргасан тэр хүмүүс 12-оос 16 онд байсан тэр хүмүүст ингээд ямар ч юугүй хамгаалалтгүй ингээд л гудамд явж байна. Асуудал байгаа бол тэд нарыг авчраад шалгаад яа л даа. Тэгээд өөрийнхөө хүмүүсийг зүгээр орхичхоод л. Тэгээд л ингээд нэг тийм барьцаалагдсан маягтай нэгэндээ хариуцлага тооцохгүй энэ байдал чинь л хамгийн гол асуудал болоод байгаа юм. Энэ чинь нийгмийг цаашдаа хамгийн том ийм үзэн ядалт, энэ бүх зүйл рүү аваачна. Энийг ингээд хэлж ярихгүй суугаад байх тусам тэр.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Асуулт, үг хамтдаа. Үгүй ээ 5 минутад багтааж асууна л гэж байгаа юм. Асууж болно гэж байгаа юм. Нэмэлт тодруулахгүй, дэгээрээ боломжгүй байна. Хэн хариулах вэ? Асуулт, үг 2 хамтдаа шүү дээ, наадхад чинь юу гэж хариулах юм бэ? ХЗДХ-ийн сайд Энхбаяр хариулъя.

Б.Энхбаяр: Пүрэвдорж гишүүний дийлэнх асуудлыг бол би асуулт гэхээсээ илүү бас байр суурь, үг гэж хүлээж авч байна. Пүрэвдорж гишүүн бол бас туршилагатай ийм улс төрч, нам дотроо бол жоохон шахагддаг юм шиг байна лээ тэр авлигачдадаа гэж би ойлгож явдаг юм. Мэдээж улс төрийн тэр нам, энэ нам гэхээсээ илүү авлига бол Монголын зовлон, хүний эрхийн дайсан болчхоод байна л даа. Тэгээд авлигаасаа салах бол тухайн улс төрийн намын өөрсдийнх нь асуудал. МАН чичлүүлээд, шүүмжлүүлээд ч гэсэн өөрсдийн авлигачдаа өөрсдөө шийдвэрлэнэ, шийдвэрлэсээр ирсэн. Хурдтай үе солигдож яваа, сайн цаг

наашилж байгаа. Хөгжлийн банкны сонсголын асуудлыг ярихад МАН-ын парламенттай олонх 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулж, парламентын хяналт хийдэг түр хороо байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Үүнийхээ дагуу сая би хэллээ. Занданишатар даргатай Улсын Их Хурал Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг гаргасан. Мөн энэ Улсын Их Хурлаас бид хамтдаа Хөгжлийн банкны хяналт шалгалтын түр хороог байгуулж, бүтэн жилийн хугацаанд өнгөрсөн 20 жилийн хугацаанд Монгол Улсад тогтсон улс төр, бизнес, банк санхүү, хууль хяналт гэсэн схемээр авлигын мафийн үнэн нүүр царайг илчилж чадсан.

Урьд нь энийг ойлгодоггүй байсан. Ард иргэдийнхээ нүдийг нээсэн. Энд ямар ч нам намчирхал талцал бариагүй. Одоо бид ирэх сард үндсэндээ 2 долоо хоногийн дараа нүүрсний сонсгол хийх гэж байгаа юм. Энэ асуудал МАН Засгийн эрх барьсан таны хэлсэн энэ он жилүүдэд дийлэнх хулгай нь яригдана. Энд намчирхал, ямар нэг дарга цэргийн хаацайлал байхгүйгээр асуудал илчлэгдэнэ, авлигачдын үнэн нүүр царайг ил болгоно. Улсын Их Хурлын танхимд яригдаж, олон удаа асуугдсан жинхэнэ хулгайч илчлэгдэнэ. Энэ дээр харин нүүрсний сонсголыг таслан зогсоох, хийлгэхгүй байх санаархалд битгий АН татан ороогдоорой. Танай нам харин одоо хүртэл энэ хулгайчид салж чадахгүй байна. Пүрэвдорж шиг шударга гишүүдээ АН харин гаргахгүй байгаад би гайхаад байгаа юм. Дандаа нөгөө өнөөх л авлигачидтайгаа 20 жил явж байгаа. Өөр намын дотоод асуудалд орох нь улс төрийн соёлгүй хэрэг гэдгийг би ойлгож байгаа. Тэгэхдээ нэгэнт ард түмэн нүүр царайг нь мэдчихсэн, энэ мафийн эздээсээ хамтдаа салцаагай гэдгийг бол би харин уриалж байна.

Л.Мөнхбаатар: Асуултад хариуллаа. Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Энэ авлигатай хэрхэн тэмцэж байгаа тухай, хэрхэн амжилттай тэмцэж байгаа тухай асар их ажил хийж байгаа тухай ингээд тайлан ирсэн байна л даа. Эндээс үнэхээр чин сэтгэлээсээ авлигатай тэмцээд байна уу үгүй юү гэдэг дээр надад бол асар их эргэлзээ байдаг. Жишээ нь эхний асуудал нь ер нь төр том байхаар, төсөв том байхаар авлига улам ихэсдэг гэдэг чинь нөгөө батлах шаардлагагүй үнэн гэж нэг зүйл байдаг аксиом гэдэг. Батлаад байх ямар ч шаардлагагүй. Энэ төр засаг авлигатай тэмцэж байгаа юм болбол яагаад энэ төр чинь томроод, төсөв чинь томроод байгаа юм бэ? Жилд 30 хувиар томроод байгаа юм бэ? Эдийн засаг 3, 4, 5 хувийн өсөлт ярьж байхад төсөв яахаараа 30 хувийн өсөлт ярьдаг юм бэ? Энэ чинь яг авлигатай тэмцэх гэж байгаа чин хүсэл мөн үү? 1 дүгээрт нь.

Тэгээд авлигатай тэмцэхийн тулд гол, гол арга хэрэгсэл гэх үү, хүлээн зөвшөөрөгдсөн гэх үү замууд байдаг. 1 дүгээрт нь авлигатай тэмцэхийн тулд төрийн бодлого шийдвэр олон зүйл нээлттэй болох ёстой гэдэг, нээлттэй болох ёстой. Гэтэл өнгөрсөн хугацаанд энэ 3, 4 жилийн хугацаанд төрийн өмчит яригдаад байгаа авлига хулгай гардаг төрийн өмчит ямар ААН-үүд нээлттэй болов? Хэдэн замын АЗЗА компанийг хувьчилсан байх. Төрийн банкны 10 хувийг хувьчилсан байх. Үгүй ээ нөгөө ямар нөгөө ТӨК-уд чинь юу нь нээлттэй болсон юм, юу ил тод болсон юм бэ? Хаалттай зүйл хаалттай хэвээрээ л байгаа. Дорж авлигач болсон болбол энэний дараа Дондог авлигач болоод л гараад л ирнэ. Яагаад гэвэл нөгөө үндсэн систем маань хаалттай ТӨК-уд тэр чигээрээ л байгаа. Дээр нь нэмээд жил дамнаад бүрэн эрхт төлөөлөгч БЭТ гээд янз бүрийн хуулиудын хориг саадыг байхгүйгээр цензургүйгээр шууд шийдвэр гаргадаг БЭТ гэдгийг жил дамнаад л ажиллуулаад байна. Үгүй ээ энэ чинь авлигын үндэс биз дээ? Энийг л бид нар авлигын үндэс гэж халж сольж энийг л өөрчилж гээсэн биз дээ. Тэгээд энэ байхад авлига нь яаж буурах юм бэ? Дахиад

дээрээс нь энэ чинь тэр нээлттэй болохын чинь үндэс компани нь бирж дээр гарахын үндэс чинь олон нийтийн хяналтад л очдог. Цөөхөн хүн л тэрийг мэдэж, хааж боож байвал энэ болбол авлигын үндэс суурь тэнд хэвээрээ л байна гэдэг. Тэгэхээр яагаад нээлттэй болгох болохгүй байгаад байгаа юм бэ өнгөрсөн жилүүдийн хугацаанд гэдэг дээр Хууль зүйн сайд бас хариулт өгөөч.

2 дугаарт нь авлигыг бууруулах нэг үндэс нь ил тод байдал гэдэг. Ил тод байдал. Тэгэхээр тэр шилэн дансны хэрэгжилт гэдэг зүйл асар хангалтгүй байдаг тухай тайлангууд харагддаг. Энэ дээрээ яагаад арга хэмжээ авахгүй байгаа юм бэ?

2 дугаарт нь сая тэр Төсвийн хуулиар орж ирсэн, Төсвийн хуулийг дагаж орж ирсэн нөгөө Хотын хуулийг дагаж орж ирсэн тэр шууд худалдан авалт хийж болох, үгүй ээ шууд худалдан авалт, тендергүй, өрсөлдөөнгүй худалдан авалт хийдэг чинь авлигын үндэс гээд бид нар хүлээн зөвшөөрдөг биз дээ. Тэгээд яагаад шууд худалдан авалт хийхийг бид нар өчигдөр, уржигдархан ингээд энэ хуулиар ингээд хэлэлцэх эсэхийг нь дэмжээд, хэлэлцүүлгийг нь дэмжээд, та нар яагаад энэ дээр дуугарахгүй яваад байгаа юм бэ? Авлигатай тэмцэж байгаа юм болбол энэ чинь хамгийн хориотой зүйл биз дээ. Ногоон автобус, нүүрсний хэрэг чинь шууд худалдан авалтаас л гарсан биз дээ. Одоо бид нар шууд худалдан авалтыг хийхээр ингээд дэмжээд явж байна.

Дараагийнх нь тэр өрсөлдөөн, авлигатай тэмцэх нэг арга зам бол нээлттэй байгаад, ил тод байгаад, өрсөлдөөнөөр ААН-үүдийн дотор асуудал шийдүүлье, нээлттэй өрсөлдөөнд оруулъя. Гэтэл сая дөнгөж саяхан бид нар баталсан Төсвийн хуулийг дагаж орж ирсэн Биржийн тухай хууль гэж байгаа. Биржийн тухай хууль дээр ТӨК-уд биржгүйгээр нүүрс зарж болно гэж байгаа юм. Шууд гэрээ хийж болно гэж

байгаа юм. Нөгөө талд нь БЭТ-тэй. Тэгэхээр энийг дөнгөж сая бид нар л ингээд батлаад. Тэгээд та нар энд авлигатай тэмцэж байна гээд байдаг. Тэгээд хэрхэн яаж ил тод биш болгох вэ, хэрхэн яаж өрсөлдөөнгүй болгох вэ, хэрхэн яаж хаалттай болгох вэ, хэрхэн яаж БЭТ томилуулж ажиллах вэ гээд энэ бүх зүйлүүд чинь ингээд яваад байхаар, сая тэр тайлан мэдээллүүд дээр гараад байгаа авлигын индекс маань хэрхэн яаж сайжирч байр маань урагшлах юм бэ?

Сүүлийн 6, 7 жилийн хугацаанд 70 хэдэд байсан орон нь 120 луу орчихлоо шүү дээ. Одоо зөвхөн саяын хууль 2, 3 хуулийн өөрчлөлтүүдийг харахад Монгол Улс дахиад авлигын индексээр дахиад хойшлох л болчихож байна. Яагаад Монголын төр авлигатайгаа үндэс сууриар нь тэмцэх хүсэл эрмэлзэлгүй байгаа юм байна гэдэг дүгнэлтийг зөвхөн энэ хуулиудаас гаргаж болохоор л болчихлоо шүү дээ. Үнэхээр хүсэл эрмэлзэлтэй байсан болбол ил тод, өрсөлдөөнтэй, нээлттэй болгоход яагаад Монголын төр анхаарахгүй байгаа юм бэ гэдэг дээр. Тэгэхээр энэ бүгд дээрээ та нэг яг саяын тэр таны илтгэлд ч гарч байна лээ. Ил тод болгож байгаа, нээлттэй болгож байгаа гээд. Би болбол ил тод биш, хаалттай, өрсөлдөөнгүй, шууд худалдан авалт? БЭТ гээд энэ олон зүйлүүд чинь ингээд яваад байна. Энэ чинь харин жинхэнээсээ авлигыг хуульчлаад байгаа юм биш үү? Авлигыг энэ хулгайг чинь хуулийн хүрээнд хий гэдгийг хамгаалж өгөөд байгаа юм биш үү гэдэг л байр суурьтай танаас асуулт асууж байна. Тэгээд энэ дээр тус бүрд нь тодорхой хариулт өгөөч.

Л.Мөнхбаатар: Асуултад хэн хариулах вэ? Энхбаяр сайд хариулъя. Ажлын хэсэг нэмж хариулж болно.

Б.Энхбаяр: Цогтгэрэл гишүүний хөндөж байгаа ялангуяа энэ чөлөөт эдийн засгийг дэмжих, төр хэт данхайж байгаа, ялангуяа төрийн төрөөс ТӨК-удаар дамжуулж төрийн юу зах зээлийн

энэ эдийн засагт хэт оролцож байгаа асуудалтай миний хувьд бол санал нэг байдаг бөгөөд би улс төрч хүний хувьд 2016 оноос хойш дэд сайд болсноосоо хойш энэ асуудлыг ярьж, тодорхой шийдэл бас гаргаж, санал болгож явдаг. Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг бид зайлшгүй шинэчилж батлах учиртай. Сая ч гэсэн би үгэндээ хэлсэн. Хаана төрийн өмч байна тэнд хулгай тасрахгүй байна. Цогтбаатар гишүүн ТӨК-удыг нэгийг ч шинээр байгуулахыг хууль гаргаж таслан зогсооё гэдэг Улсын Их Хурлын тогтоолын төсөл өргөн барьсан. Улсын Их Хурал дэмжчихээд байгаа. ЗГ-аас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг өргөн бариад миний бие өөрөө ХЗДХ-ийн сайд болохоосоо өмнө энэ хуулийн төслийг Улсын Их Хурал дээр ажлын хэсгийг нь ахлаад, одоо Улсын Их Хурал дээр анхны хэлэлцүүлгийг нь хийхэд бэлэн болгоод байна.

Энэ шинэтгэлээр төрийн болон орон нутгийн өмчтэй холбоотой бүхий л асуудлаар шийдвэр гаргалтыг нэн тодорхой болгоно. Хариуцлагыг ч мөн тодорхой болно. Эрдэнэтийн 49-өөс эхлээд, ард түмний төлөөллийн дээд байгууллагаар оруулалгүйгээр хэдэн их наяд төгрөгийн ордыг нь үйлдвэртээ авч байсан асуудал, Дубайн гэрээнээс эхлээд байгалийн баялаг ард түмэнд хүртээх үзэл санааг 1 Ерөнхий сайд нь ЗГ-ынхаа танхим ч танилцуулалгүйгээр гадаад улсын компанийн захирлын гал тогооны өрөөнд шийдвэрлээд, өнөөдөр ард түмнийхээ нүүрийг харж чадахгүй зугтаад явж байгаа асуудал байна. Тэр Ерөнхий сайдыг өнөөдөр ард түмэн нь хууль хяналтын байгууллага нь төр нь авчрах гээд өчигдөрхөн уржигдархан манай яам АНУ-ын авлигатай тэмцэх байгууллагын албаны хүмүүстэй уулзалт хийгээд явж байгаа асуудал. Энэ бүх асуудлын суурь өмч хаана байна, тэнд ард түмэн нээлттэй хяналт тавих тухай хууль эрх зүйн шинэтгэлийг хийхгүйгээр амжилт олохгүй. Энэ шинэтгэлийг бид хамтдаа дэмжиж, энэ намрын

чуулганаар батлах учиртай гэж ингээж үзэж байна. Таны хэлсэнчлэн төр өөрөө хамгийн боломжит хэмжээнд цомхон байх учиртай, шилэн байх учиртай. Энэтэй би санал нэг байдаг. ТӨК-удын засаглалын асуудлуудыг олон схемээр дүр зургаар нь бид бол харах боломжтой. Тун удахгүй бид 2 долоо хоногийн дараа Цогтгэрэл гишүүн бид 2 нүүрсний түр хороонд цуг байгаа. Энэ асуудлыг хамтдаа нам үл харгалзан илчилж, ард түмэндээ ил болгоно. Үүний төлөө байгаа.

Өрсөлдөөнөөр шийдэж байх ёстой. Төсөв үнэхээр томроод байгаа. Төсвийн ард мөн төсвийн хулгай байдаг гэдэг асуудал олон жил яригдсан. Бид энийг хамтдаа хамгийн дээд түвшинд хувь тэнцүүлсэн тогтолцоог оруулж ирж байж, тойрог тойрог руу чирэгдсэн, дарга дагасан төсвийг таслан зогсоох Сонгуулийн хууль, Улс төрийн намын хууль, санхүүжилтийн хууль мөн хувь тэнцүүлсэн элементийг оруулж ирж байж энэ асуудлыг шийднэ. Энэ шийтгэлийн төлөө парламентын олонх ба цөөнх бас хамтдаа зогсож, засаглалын дээд түвшнийхээ асуудлыг бас хамтдаа шийдэж яваа. Бид алхаж яваа. Тийм ч учраас миний бие хэлсэн олон, олон хулгай луйврууд гараад байгаа нь ард иргэдийг бухимдуулж байгаа. Тэгэхдээ энэ өөрөө ардчиллын давуу тал байгаа. Бид олон ургалч үзэлтэй, нээлттэй, хяналттай парламентын засаглалын давуу тал байгаа. Энэ засаглал өөрөө, өөрөө энэ асуудлуудыг бас илчилж манлайлж явж байгаа. Мөн шүүрдэж явж байгаа.

Л.Мөнхбаатар: Таны асуултад хариулсан. Цэвэгдоржийн Туваан гишүүн асуултаа асууя.

Ц.Туваан: Энэ асуулт бас хүнд асуулт асуудал энэ авлигын асуудал. Монгол Улс нэг тийм хачиг хувалздаа баригдсан, хамуундаа баригдсан ийм нэг таталдаж байгаа борлон шиг л болчихоод байгаа юм. Энэ нь бол авлигад баригдчихаад байгаа юм. Дээрээс нь энэ

бүх л түвшинд ерөөсөө эрх барих дээд байгууллага, засаг, дунд шат, анхан шат гээд ингээд ерөөсөө бүх шатдаа хуулийнхан дотроо ч тэр ийм системийн авлига гэдэг юманд өртчихөөд байгаа юм. Нэг зүйлийг, нэг хүнийг барьж асуудлыг нь шийдээд энэ бол эмчлэгдэхгүй. Тэгэхээр энэ дээр бол нэлээн том хэмжээний бодлогын асуудал, бүх хүмүүс нийлж, тэр нам улс төржихгүйгээр нэгдэж нийлж явж байж энэний ард гарна. Ажлын хэсгийнхнээс энэ Трансперенси интернэйшнл гээд байгууллага дээр нэг тоо нэг хэлээд өгөөрэй. 2012-оос 16 он, 16 оноор яг хэдэд байсан юм бэ? Хамгийн сүүлийн 22, 23 оноор хэдэд байгаа юм бэ? Хэдүүлээ бас асуудалд нэг тийм бодитойгоор хандъя. Нэг нэгнийгээ харлуулахаасаа илүүтэй, тэрийг бас нэг тоогоор нь төддүгээр байранд байна гээд хэлчхээрэй.

2 дугаарт энэ Их Хурал дээр нэг бүтэц бий болсон. Түр хороо, хянан шалгах эрхтэй ийм түр хороогоор асуудлыг шийддэг. Энийг бол дэвшил гэж харж байгаа юм. Тэгээд энэ дээр цөөнхийн бүлэг өнөөдөр ингээд асуулт асууж байгаа шиг, цөөнхийн бүлгийн гишүүд нэг санал тавиад ингээд тухайлбал би тэр Ковидын түр хороог ярьж байна л даа. Үгүй ээ энэ чинь ард түмэн асуугаад байгаа. Бид бүхэн ард түмний төлөөлөл. Түүн дээр энэ олон их наяд төгрөг чинь, тэр олон пүүс компани гаднын байгууллагаас орж ирсэн мөнгө чинь хаашаа орсныг та нар ингээд сөрөг хүчин асуу гээд ингээд явахаар тэр Түр хороонд юу шинжээч, мэргэжлийн шинжээч томилж өгч болдоггүй. Бид нар чинь ямар Их Хурлын гишүүн болохоос ямар шүүгч, прокурорууд биш, ийм ажиллагаа явуулж болохгүй. Тэгэхээр энэ асуудал дээр хүртэл ийм алагчлалтай 2 double стандартаар хандаад байгаа явдал дээр бол харамсаж байгаа юм.

Дараа нь энэ ер нь бол энэ хөгжингүй орнуудад л авлига бага байгаа шүү дээ. Монгол Улс бол хөгжчихөж болохоор гуравхан сая хүнтэй, гадныхны

шоглож хэлдгээр алтан дээр суусан гуйлгачин байдалтай, Голланд өвчиндөө баригдчихсан ийм л байгаа шүү дээ. Тэгэхээр энэнээс гараад хөгжсөөд иргэд нь баян болоод, мэдлэг боловсролтой болоод, мэдээлэлтэй болж ирж байж авлига багасна. Тэгэхээр энэ бол том улс орны том хөгжлийн асуудал яригдаж байгаа. Тэгэхээр энэ дотор иргэдээ баяжуулах тал дээр Үндсэн хуулийн аль дээр бид нар бараг 5 жилийн өмнө баталчихсан шүү дээ. Үндсэн хууль дагаад энэ Баялгийн сангийн тухай хууль гээд энэ уул уурхайгаас орж ирж байгаа баялгийг иргэддээ тэгш хуваарилах энэ хуулийг ер нь яагаад оруулж ирэхгүй байгаа юм бэ? Яагаад иргэдийг бас нэг 5 цаастай, асуудлаа шийддэг, өөрсдөө энэ орны эзэн болсны хувьд баялгаасаа хувь хүртэх байдлаар, байдалтай энэ бий болгох хуулийг оруулж ирэхгүй байгаа юм бэ? Энийг бол яаралтай оруулж ирмээр байгаа юм.

Саяхан бид нар улсын төсөв баталсан. 20 оны төсвөөс даблдаж буюу нэг дахин өссөн төсөв 27 их наядын төсөв баталсан. Нөгөө авлига гээд яриад байгаа энэ дотор чинь төсвийн авлига явж байна шүү дээ. Сонгуульд зориулсан, сонгогчид руу зориулсан авлига явж байна шүү дээ. Хүмүүсийн цалин нэмнэ л гэнэ, тэтгэвэр ойрхон, ойрхон нэмнэ л гэнэ, Монголбанк нь энийг болохгүй инфляц өдөөнө гээд байхад л нэмж байгаа юм. Энэ бол төсвийн авлигын нэг жишээ. Тэгээд юугаар батлагдаж байна гэхээр сонгуульд санал өгөхгүй хүүхдүүдэд болохоор тэр цэцэрлэгийн хүүхдийн хоолны мөнгө, үдийн хоолны, мөнгө дотуур байрны хүүхдийн хоолны мөнгөн дээр бол эс мэдсэн царайлаад чихгүй толгойлоод өнгөрч байгаа байхгүй юу. Тэд нар санал өгөхгүй учраас. Тэгэхээр иймэрхүү байдалтай юмнууд зөндөө байна. Тэгэхээр энийг бол улс төржилгүйгээр бүгдээрээ нийлж, ил тод шилэн болгож, ингэж тэмцэж байж ард нь гарна. Иргэд хөрөнгө чинээтэй, баян хүнээс хамааралгүй, хүнээс юм гуйхааргүй болж байж авлигын энэ индексүүд чинь

буурна шүү гэдгийг бас энэ таширамд хэлье. Тэгээд үг хэллээ. Транспаренсигийн тоонуудыг ажлын хэсгээс асууцхъя.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг хариулъя. Ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье. Нэр, албан тушаалаа хэлээд асуултад хариулаарай.

Б.Солонгоо: ХЗДХ-ийн дэд сайд Солонгоо. Туваан гишүүний асуултад хариулъя. Трансперенс Интернэйшнал олон улсын ТББ-аас бол авлигын төсөөллийн индексийг бол жил болгон жил бүр гаргадаг. Тэгээд нийт 180 орчим улсыг 0-ээс 100 оноогоор үнэлээд, тэгээд тухайн улсын авлигын төсөөллийн индексийг бол гаргаж байгаа. Тэгээд 2022 оны байдлаар Монгол Улс 33 оноо авсан, тэгээд 33 оноогоор нийт 180 улсаас 116 дугаар байранд бол орсон байна. Яг өнгөрсөн жилүүдэд бас харьцуулаад үзэхээр 2012 онд манайх 36 оноотой байсан. Тэгээд ер нь бол сүүлийн жилүүдэд бол манай суурь эдийн засгийн болон засаглалын бусад индексүүдийн үзүүлэлтээс харгалзаад бас энэ төсөөллийн индекс маань бол өөрчлөгддөг. Энэ жилийн хувьд бол ирэх оны энэ жилийн бол төсөөллийн индекс хараахан гараагүй байна. Цаашидаа бид нарын хувьд бол анхаарах зүйл маань эдийн засгийн өсөлтийг тогтвортой байлгах, хамгийн гол нь бас эдийн засгийн өсөлт маань нийт хүн амд маань хүртээмжтэй тэгш байх, цаашидаа бас засаглалын болон суурь институтийн хөгжлийг бас тогтвортой хангахад бол энэ төсөөллийн индексийг бол сайжруулахад бас гол чухал анхаарах зүйлс байгаа.

Тэгээд авлигын төсөөллийн индексийг бас цаашид бол сайжруулахад хийгдэх шаардлагатай ажлууд маань яг хууль, эрх зүйн орчин гэхээсээ илүүтэйгээр манай эдийн засгийн нөхцөл ялангуяа уул уурхайн эдийн засгаас бас их хамааралтай байдаг эдийн засаг маань. Тогтвортой хөгжих, үүнийгээ дагаад бас иргэдийн маань орлого бас яг

тогтвортой хүртээмжтэй байх, ДНБ бас хэмжээ нь бас жил бүр тогтмол өсөлттэй байх нь бас энэ авлигын төсөөллийн индексэд бас эерэг нөлөө үзүүлдэг гэсэн бас судалгаанууд байна. Тэгэхээр цаашидаа бас эдийн засгийн өсөлтийг хангах чиглэлээр бол ажлууд хийх нь бас шаардлагатай байгаа. Тэгээд энэ үүнтэй холбоотой бас ажлын хэсгийг Эдийн засаг хөгжлийн сайд Хүрэлбаатараар ахлуулахаар бас ЗГ дээр шийдвэр гаргаад бол ажиллаж байна.

Яг энэ төсөөллийн индекстэй холбогдуулаад бас өмнөх жилүүдийн статистикийг аваад үзэхээр бидний хувьд бас суурь яг ямар засаглалын бас болон эдийн засгийн бусад судалгааны материалууд дээр үндэслээд энэ авлигын төсөөллийн индексийг бас гаргадаг юм бэ гээд бас нэлээн бас дүн шинжилгээ бол хийсэн. Тэгээд энэ дүн шинжилгээг аваад үзэхээр дэлхийн бас олон улсын судалгааны болон нэр бүхий бас судалгааны байгууллагуудаас бас гарсан болон төрийн бус байгууллагуудаас гарсан судалгаанууд дээр бол үндэслэдэг. Эдгээр судалгаанууд маань бол жишээ дурдах юм бол Эдийн засагчдын чадавхын нэгж, улс орнуудын эрсдэлийн үнэлгээ, Олон улсын эрсдэлийн удирдамж, ардчиллын олон талт байдлын үнэлгээ, Дэлхийн өрсөлдөх чадварын төв, удирдах ажилтнуудын асуулга, судалгаа, Бертелсман шилжилтийн индекс, Дэлхийн банкны улс орны бодлого, байгууллагын үнэлгээ, Глобал инсайт улс орнуудын эрсдэлийн зэрэглэл, дэлхийн эдийн засгийн форум удирдах ажилтнуудын асуулга судалгаа, дэлхийн шударга ёсны төсөл хууль дээдлэх ёсны индексийн судалгаа гэсэн суурь судалгаанууд дээр бол үндэслэж бас Авлигын төсөөллийн индекс маань бол гардаг.

Тэгээд цаашидаа бас түрүүн дурдсан эдийн засгийн өсөлтийг тогтвортой хангах, манай улсын бас суурь институтийн хөгжлийг тогтвортой байлгах нь цаашидаа авлигын

төсөөллийн индексийг бас бууруулахад чухал ач холбогдолтой.

Л.Мөнхбаатар: Тодруулах дэг байхгүй, 5 минутад багтааж асуулт асууж, үг хэлж болно. Яах юм бэ нэмж хариулах боломж байгаа юм уу, нэг бол дараа нь юугаар өгөх юм уу, хариулах юм уу? Ажлын хэсгийн 81 дүгээр микрофоныг өгье, нэмээд харуулчихъя.

Б.Солонгоо: Авлигын төсөөллийн индекс яг сүүлийн бас 10 жилээр манай Монгол Улсын бас үзүүлэлт ямар байсан бэ гээд бас статистик мэдээллийг харвал 2012 оноос хойш бол 36 оноотой байсан, энэ оноонууд маань бас жил болгон бол хэлбэлзэж байсан, бас тогтмол бас оноо бол яг байсан бас үзүүлэлт бол байхгүй байна. Тэгээд энэ хэлбэлзэж байсан онооноос сая бас Туваан гишүүн 2016 оныг бол онцолж асууж байна. 2016 онд 37 оноотой байсан байна. Тэгээд 2022 оны байдлаар түрүүн би дурдсан, яг байрлал бол одоогоор надад мэдээлэл бол байхгүй байна. Тэгээд 2022 оны мэдээлэл бол 33 оноотой, 116 дугаар байранд байна.

Л.Мөнхбаатар: Асуултад хариулсан. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Яасан гэнэ вэ? Дэгийнхээ дагуу удахгүй яригдана. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109.11-д заасны дагуу Д-парламент цахим хэлэлцүүлгийн платформ дээр байриуулсан Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн саналуудыг ЗГ-ын гишүүнээс асууна. Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, ХЗБХ-ны дарга Дамдины Цогтбаатар ЗГ-ын гишүүнээс асуулт асууна. Асуулт хариулт 20 хүртэл минут байгаа гэдгийг хэлье. Асуултаа асууя. Дамдины Цогтбаатар гишүүний микрофоныг өгье.

Д.Цогтбаатар: Гишүүддээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Тэгэхээр сая

Их Хурлын дэд дарга дурдлаа. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109.13-д заасны дагуу манай бүлэг дээр эмхэлж нэгтгэсэн энэ иргэдээс ирсэн цахимаар ирсэн асуултуудыг нэгтгээд энэ асуултуудыг бол сайдаас энэ иргэдийн асуултуудыг иргэдийг төлөөлж асууж байна. Тэгэхээр энд ер нь зүгээр сая юунаас сөрөг хүчнийхний ярьж байгаагаас ч, энд иргэдийн асууж байгаа асуултаас ч харахад үнэхээр засгийн эрх барьж байгаа намын хувьд, Засгийн хувьд анхаарах олон асуудлууд байна. Тэгэхээр энэ дээр асууж байгаа асуултууд үнэхээр бас ноцтой, бид нар анхаарал зайлшгүй хандуулах ёстой асуултууд байгаад байгаа юм. Жишээлбэл Өлзийбаяр, Өлзийбаяр гээд иргэн асуусан байна л даа. Энэ ингээд улсад хохирол учруулсан энэ албан тушаалтнуудын энэ бүх эд хөрөнгийг хураах ёстой, ийм юм яг бодитой ямар ажил хийгдэж байна вэ? Улсын энэ эд хөрөнгийг нь улсын орлого болгоод зогсохгүй тийм хүмүүсийг бол 5-аас дээш жилээр төрийн албанд орох эрхийг нь хязгаарлах ёстой гээд ингээд заасан байна. Тэгэхээр энэ дээр тодорхой хуульд мэдээжийн хэрэг өөрчлөлтүүд орсон байгаа. Гэхдээ энд иргэн бүүр асууж байна л даа асуухдаа бүүр тэр төрийн албанд орох эрхийг нь бүүр үр хүүхэдтэй нь хамт хязгаарлаад явах ёстой гээд л асуусан байна. Энэ дээр тэгэхээр эрх зүйн хүрээнд яг ямар, ямар ажлууд хийгдсэн байгаа, хуулийн бодит заалт санкцууд юу байгаа энэ талаар бас нэг манай энэ Өлзийбаяр гээд иргэний асууж байгаа асуултад хариулт өгөх нь зөв байх. Нэг асуулт нь ийм байна. 2 дахь асуулт бол энэ яг АН-ын саяын гишүүдийн асуугаад байгаа.../үг тасрав/

Л.Мөнхбаатар: Цогтбаатар даргаа яах юм бэ? Та асуултдаа иууд хариулт тавиад явах юм уу, яаж, бүгдийг нь асуучхаад нэгмөсөн хариулах гэж байна уу? Та өөрөө ямар бодолтой ямар бодолтой байна вэ?

Д.Цогтбаатар: Ер нь тэгвэл нэгийг асуугаад хариулт аваад явж болж байна.

Л.Мөнхбаатар: Тэгвэл ХЗДХ-ийн сайд Энхбаярын микрофоныг нээчих. Тэгээд харилцан асуултаа асуугаад, хариулаад явчихъя.

Б.Энхбаяр: Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хууль тогтоомжид гэмт хэрэг үйлдэж олсон хууль бус орлогыг хураах хураадаг. Мөн энэ эд хөрөнгө хураах ял бас нэмэгдэл ялын шинж чанартайгаар үйлчилж байдаг. Яг хэчнээн төгрөгийн хөрөнгө хураагаад байгаа гэдэг АТГ тоо байна уу?

Үр хүүхдээр нь л хуртэл хэлмэгдүүлье гэж. Энэ бол Үндсэн хууль зөрчинө. Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар гэм буруутны ял зэмлэлийг гэр бүлийн гишүүн, үр хүүхдэд нь халдаан хэрэглэхийг хориглодог. Буруу үйл үйлдэл хийсэн бол тэр хүн өөрөө цээрлэлээ эдлэх ёстой. Тэрнээс хэн нэгний хүүхэд гэдгээр нь, үр удмаар нь, хэдэн үе дамжиж цээрлүүлдэг ийм юм байхгүй. 1937 онд хэлмэгдүүлэлтийн жилүүдэд гэр бүлийг нь, эхнэрийг нь, хүүхдийг нь давхар хэлмэгдүүлдэг ийм хэлмэгдлийн он жил бол байсан. Бид энэ түүхийг давтахгүй. Тухайн гэмт авлигачны хөрөнгийг хураах хууль тогтоомж Эрүүгийн хуулиар бол үйлчилж байгаа гэдгийг хэлье.

Л.Мөнхбаатар: Цогтбаатар.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс нөгөө хэр их эд хөрөнгө.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг хэн хариулах юм бэ, урдах дугаараа өргөөрэй. 88 уу? Ажлын хэсгийн 88 дугаар микрофоныг өгье. Нэр, албан тушаалаа хэлээд асуултад хариулъя.

Ч.Жаргалбаатар: Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн Албаны дарга Жаргалбаатар асуултад хариулж байна.

Эрүүгийн хуулийн энэ 7.5 дугаар зүйл дээр бол хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг хуульчилж өгсөн. Энд бол гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө орлогыг эсхүл бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээг болбол хэрэглэж байгаа. АТГ-ын хувьд 2021 онд болбол 96,2 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн. 22 онд 2 их наяд хөрөнгийг болбол нөхөн төлүүлсэн. 23 оны 10 сар гарснаар болбол зуун, зуу, өнөөдрийн байдлаар яг сүүлчийн байдлаар яг ингээд тооцоод үзэх юм бол 181 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн. Мөн энэ хохирлыг нөхөн төлүүлэх барагдуулахтай холбоотойгоор тодорхой хэмжээний хөрөнгүүдийг хамгаалах ажиллагаануудыг буюу битүүмжлэх ажиллагаануудыг хийсэн байна.

Д.Цогтбаатар: Баярлалаа. Энэ би саяын энэ асуултыг бүүр яг ингээд энэ иргэн ингэж асууж байна шүү гэж Хууль зүйн сайдаас асууж байгаа юм. Тэгэхээр тэр ялангуяа үр хүүхэд нь ингээд хамруулна гэдэг дээр Хууль зүйн сайд ер нь аль ч түвшиндээ нэг зүйлийг зоригтой бас нэг ярьж сурахгүй бол энэ мессежээ бас хатуу өгч байх ёстой. Юу гэвэл буруутай хүн бол хариуцлага хүлээнэ, заавал хариуцлага хүлээнэ, гарцаагүй хүлээнэ. Гэхдээ энэ чинь соёл иргэншсэн улсын хууль дээдлэх зарчмын тухай ярьж байхад бид нар хуулиа дээдэлнэ гэдэг чинь буруутай хүндээ л хариуцлага хүлээлгэнэ. Түүнээс энэ чинь нөгөө өшөө авах процесс биш. Энэ яг иргэдийн энэ асуулт дунд бол үнэхээр нийгмийн бухимдал нэлээн байгаа учраас энэ сүүлдээ энэ хорсол болж хувираад, яг өөрийн чинь тэр ярьж байгаа нөгөө хоморголох гээд, огт хамаагүй хүмүүс рүү нялзааж халдаах гээд байгаа ийм нөхцөл байдал байгаа учраас Хууль зүйн сайд саяын тэр хариултаа бол өөр олон газар ч танаас энийг асууна. Энийг яг саяын зарчмаараа бас хатуу үйлдэж байх нь зөв байх гэж би бодож байна. Өөрөөр хэлбэл буруутай хүмүүс бол хариуцлага хүлээнэ буруу үйлдлийнхээ төлөө. Энийг бол тэр буруу хийсэн

хүмүүст нь л хариуцлагаа тооцно гэдгийг. Түүнээс энэ хуулийн өшөө авах тухай ямар нэгэн ойлголт байхгүй шүү гэдгээ хатуу хэлж байх нь зөв байх.

Бас Оюунтуяа гээд иргэн асуусан байна л даа. Энэ яг АН-ынхны асуугаад байгаа зүйлийг асуугаад байна. Энэ ингээд Авлигатай тэмцэх индексээр нэлээн дээгүүр орчихсон байсан юмыг хэчнээн юугаар шатаар арагшаа ухраачихсан байна. 8 жил МАН Засаг барилаа, тэгээд ингэж ухарна гэдэг чинь бүүр тэрэнтэй тэмцэх гэж юм хийсэн биш бүүр эсрэгээрээ харин энэ авлигыг чинь дэмжээд өгчихсөн юм биш үү? Үгүй ээ энэ дээр тэгээд ер нь хэдэн хүнд хариуцлага тооцчихоод байна вэ? Яг энэ бодитой тоонуудаа яриач гэдэг юм асуугаад байна. Тэгэхээр энд түрүүний хариултууд ч бас гарч байсан учраас энэ дээр ахиад бас хариулчихна биз. Яг одоо энэ хэдэн хүмүүст энэ авлигын хэрэгтэй холбогдуулаад өндөр албан тушаалтнуудад арга хэмжээ аваад хариуцлага тооцоод байгаа юм бэ?

Би энэ дээр нэг асуулт нь яг нэмээд асууцхмаар байна. Мэдээжийн хэрэг богино хугацаа үлдсэн байгаа. Гэхдээ Хууль зүйн яам ямар хугацаанд бид нар өнөөдөр тэр 116-д байгааг 110 дээр, 80 дээр, 70 дээр авчирна гэж бодож байгаа юм бэ? Энийг мэдээж сонгууль болоод юм өөрчлөгдөх байх. Гэхдээ Монгол төрийн бодлогын залгамж чанар гэж байна шүү дээ. Ийм зөв юм бол залгамжлагдаад явна шүү дээ, дараагийн Засгийн үед ч гэсэн. Тэгэхээр тэр бодлого, төлөвлөгөөгөө энэ гаднын индексээр бид нар 8 жилийн дараа, 4 жилийн дараа тэнд ирнэ, тэгэхийн тулд ийм үйл ажиллагаанууд хийнэ гэсэн яг ийм тодорхой төлөвлөгөө, хийх ажлын төлөвлөгөө байгаа юу, хөтөлбөр байна уу?

Б.Энхбаяр: Сая АН-ынхан ч гэсэн хөндөөд байгаа юм. Манай үед 70 хэд байсан танай манай үед 77 байсан, танай үед 78 болчихсон, танайх муу авлигачин гэж ийм юм байхгүй. Бидний зорилго бол

авлигагүй бүүр нийгмийн төлөө, авлигагүй төрийн төлөө байгаа. Тэрнээс биш нэг хэдэн байраар урагшлах тухай бие биеийгээ хуурсан тийм зорилго байхгүй. Тэр 70 хэдэд байсан гээд байсан тэр үед чинь энэ нүүрсний хэргүүд гарсан байна лээ шүү эхнээсээ. Элбэгдорж гэж Ерөнхийлөгчийг байхад Дорлиг гэж, Дорлигжав гэж хүнийг Ерөнхий прокурор АН-ын дарга байсан хүн, Хууль зүйн сайд байсан. Энэ шалгагдаж байсан бүх хэргүүд хэрэгсэхгүй болж хаагдсан байна лээ нүүрсний. Хэрэв тэр үед хуулийн хариуцлага тооцож энэ бүхнийг илчилж байсан бол өнөөдөр бид нар энэ үр дагаврыг яриад суухгүй байх байсан байна лээ шүү. Одоо энэ тэр үед хаагдсан байсан нүүрсний гэх 10 орчим хэргийг бүгдийг нь сэргээж шалгаж байна. Бүгдийг нь сэргээсэн.

Тийм учраас би түрүүн хэлээд байна шүү дээ. Энд яг хэдэн хүнд ингээд л тэр үед ингээд хариуцлага тооцож байсан юм бэ гэж. Тэр үед хариуцлага тооцох байтугай хаацайлаад өнгөрдөг байсан байхгүй юу. Одоо ингэж олноороо олон хүмүүс нэр усаараа цоллогдож, хариуцлагын асуудал, нийгмийн бухимдалд бухимдал төрүүлж байгаад харамсалтай байгаа. Тэгэхдээ нуухгүй байгаа, муугаа нуухыг хүсэхгүй байгаа, муугаасаа харин салахыг хүсэж байгаа байхгүй юу. Муугаа нуухыг биш, муугаасаа салахыг хүсэж байгаа байхгүй юу эсрэгээрээ. Энэ бол ардчилсан тогтолцооны давуу тал. Бид улс төрд нөлөө бүхий бүх этгээдүүддээ оногдуулах ял шийтгэлийн бодлогыг өөрчилж байгаа. Яг бодитойгоор бид харах юм бол өнөөдрийн төрийн алба улс төрийн ертөнцөд хэдэн жилийн өмнөх шиг нийлээд хулгай хийчихье, хуйвалдчихъя гэдэг ярьдаг юм лав энэ Төрийн ордноос эхлээд би байхгүй болж байгаа гэж хардаг юм шүү. Одоо бүх юм ил болж байгаа. Би тийм учраас би сайн цаг ирж байгаа гэж түрүүн хэлсэн байхгүй юу. Сайн цаг наашилж байгаа. Шинэ үе өөр болж байгаа. Шинэ үеийг аргалах, хаацайлах, нуух аргагүй болсон. Би тийм учраас ард түмэн сэрсэн гэж

хэлж байгаа байхгүй юу. Ард түмэн сэрсэн. Хууль хяналтын байгууллагад Хурц мэтийн нөхдүүд хууль бус ажил хийж, тэрийгээ хулгайч нөхдийг төмсөгдөх, авлигадах байдлаар эрх мэдэл албан тушаалд хүрч, мөнгөждөг явдал хууль хяналтын байгууллагад цаашид байхгүй болох ёстой.

Тийм учраас би мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулдаг явдлыг таслан зогсоох ёстой гэж ярьж байгаа юм. Тийм учраас би хүнийг цагдан хорьдог, баривчилдаг асуудлыг 100 хувь шүүхийн хяналтад оруулах хуулийн төсөл санаачлаад өнөөдөр Улсын Их Хурал хэлэлцээд явж байна. Энэ бүхэн цогцоороо өөрөө улс төрийн манлайлал бөгөөд бидний хамтын үр дүн гарах ёстой. Бидний ард хамтын үр дүн өнөөдөр гарч байгаа, бидний хамтын үр дүн бас маргааш гарна. Маргааш гарна.

Д.Цогтбаатар: Энд Хууль зүйн сайдын саяын ярьж байгаа нэг зүйлд логик бас бий шүү. Ямар юу гэхээр гадаад үгүй ээ, үгүй үнэндээ ийм байгаа юм. Манайхан гаднын тоо баримттай, би бол гаднынхантай, энэ гаднын мэдээлэл юмнуудыг бол маш нарийн өөрөө уншиж үзэж байдаг хүн. Энэ биднийг ажлаа хийх чиг баримжааг гаргаж өгч байгаа болохоос биш энэ дээр нэг гаднынхны төлөө бид нар амьдраад байгаа юм шиг, гадаадынханд гоё харагдах гээд байгаа юм шиг ийм юм байхгүй шүү. Саяын энэ Энхбаяр сайдын хэлж байгаа нэг зүйл үнэн. Бид ерөөсөө авлигагүй л байх ёстой байхгүй юу. Юун 77. 77 чинь ичмээр байр байхгүй юу. Харин тэгэхээр энийгээ улам буулгах тухай л яриад, эцсийн тэр зорилго миний сонсох гэсэн юм энэ байхгүй юу. Эцсийн зорилго тэр 77 дээрээ буцаж буухдаа ч биш, ерөөсөө авлигагүй л байх ёстой байхгүй юу. Энийгээ л хэдүүлээ тал талдаа бас ярьж явах нь зөв байх. Юу яая үгүй ээ, Цогтгэрэл гишүүнээ, би тэгж яриагүй байна шүү дээ. Би эсрэгээрээ энэ тоо бидэнд баримжаа өгч байгаа тэр чиглэлийг бид нар барьж ажиллах ёстой

гэж хэлж байгаа шүү дээ. Би хэзээ ч энийг үгүйсгээгүй.

Би өөрөө энэ тоонуудтай чинь маш их ажиллаж, хамгийн их би Фрийдом Хаус, Бертелсмен, одоо энд ярьсан харин бүх тоо индексийг би ярина шүү, тийм, бүүр тэр байгууллагуудыг нь би өөрөө ч бүгдээрээ тэр судалгаа юмнууд гаргадаг хүмүүстэй нь зөндөө олон удаа, олон жил ажиллаж байсан. Тэгэхээр би энэ тоонуудтай нь ажилладаг. Энэ дотор харин IRI-ний тоог ярихгүй байгаад байна. IRI-ийн судалгааг ч гэсэн аягүй сайн үзэж байх ёстой. Яагаад гэвэл тэд нар яг Монголын нийгэм дотроос мэдээллээ авч, аягүй нарийн судалгаагаа хийсэн байдаг юм. Юун дээр энэ ногоон автобусны асуудал Батмөнх гишүүн гээд Батмөнх гишүүн гэнэ, Батмөнх гээд иргэн бас асуусан байна. Ногоон автобусны асуудлаар нэлээн юмнууд асууж. Тэгээд энэ дээр нэг ийм юм байна. Ер нь яг энэ автобус, нийтийн тээвэртэй холбоотой энэ асуудлууд хэр гүнзгий энэ дээрээ судалгаа, энэ хяналтаа тавьж байна вэ? Хариуцлага хэдэн хүнд тооцоод байна вэ? Тэгээд ерөөсөө энэ авлигатай тэмцэнэ гэдэг чинь зүгээр нэг ингээд гэмт хэрэг хийчхээд байгаа хүмүүстэй тэмцэхээсээ гадна, тэр нөхцөлдүүлж байгаа хүчин зүйлтэй нь, суурь ойлголттой нь хэр тэмцэж байна вэ гэдгийг, тэрэн дээр тэр үзэгдэлтэй нь хэр тэмцэж байна вэ гэдгийгээ гаргаж өгөөч гэсэн юм ярьж байна лээ, асуусан байна. Тэгэхээр энэ дээр тэр нөхцөлдүүлж байгаа хүчин зүйлүүдтэй хэр үзэж байна вэ?

Тэрний гадна би бас өөрөө нэг асуулт ер нь нэмчихмээр байгаа юм. Юу гэвэл ер нь энэ төрийн худалдан авалт гэдэг механизм чинь л жинхэнэ өөрөө авлигын аягүй том машин байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр энэ тэр төрийн худалдан авалтыг хэмжээг нь ерөөсөө угаасаа багасгах энэ чиглэлийн ер нь ямар бодлого явж байна вэ? Энэ чинь нөгөө тэр нөхцөлдүүлж байгаа хүчин зүйлтэй тэмцэж байгаа хамгийн гол аргынх нь нэг

байх гэж бодож байгаа юм. Энэ асуултыг асууя.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг хариулъя. Ажлын хэсгийн 88 дугаар микрофоныг өгье, асуултад хариулъя.

Ч.Жаргалбаатар: АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн албаны дарга Жаргалбаатар асуултад хариулж байна. ЭХХШТХ-д хуульд зааснаар болбол ер нь мөрдөн байцаалтын ажиллагаа явагдаж байгаа хэргийн талаар бол дэлгэрэнгүй мэдээлэл өгөх бололцоо байхгүй. Түрүүний гишүүний асуулт дээр болбол нийт хэчнээн хэрэг шийдвэрлэгдээд байгаа юм бэ гэдэг асуулт асуугдсан. Энэ дээр АТГ 2021 онд 1307 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулаад 269 хэргийг шүүхэд шилжүүлэх санал гаргасан. Үүнээс 160 хэрэг нь шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн байна. 2022 онд 1500, 1520 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулаад 262 хэргийг шүүхэд шилжүүлэх санал гаргаж, шүүхээс 188 хэргийг шийдвэрлэсэн. 23 оны 10 сарын байдлаар 1665 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулаад 113 хэрэг өнөөдрийн байдлаар шийдвэрлэгдсэн байна. Энэ хулгайлагдсан хөрөнгөтэй холбоотой буюу энэ шилжүүлэн авах ажиллагаатай холбоотой бол Энхбаяр гишүүний түрүүн тайланд дурдагдсан 12,2 сая ам.доллар гээд. Энэ 4-хөн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулахад Монгол Улсаас албан тушаалтнууд хулгай хийж аваад, гадаад улсад аваачаад байршуулаад нуучихсан энэ хөрөнгө болбол энэ 12,2 сая долларыг болбол сүүлийн жилүүдэд буцааж авчирсан байна.

Хамгийн сүүлчийн байдлаар болбол одоо энэ он, энэ оны оны дундуур 540 мянган ам.доллар-ыг яг Латви улсад ббитүүмжилчихсэн. Тухайн хөрөнгийг буцаан авах ажиллагааг тухайн улсын хуулийн байгууллагуудтай хамтраад буцаан авах ажиллагаа хийгдээд явж байгаа. Хэрэг шийдвэрлэсэн, хохирол хөрөнгийг гадаад улсаас буцаан авсантай холбоотой мэдээллүүдийг өглөө.

Д.Цогтбаатар: Туяацэцэг гишүүн, Туяацэцэг гээд иргэн бас асуусан байна л даа. Энэ банкны хүүг ер нь бууруулах боломж байгаа юу? Банкны хүүг бууруулаад энэ дээр юу тодорхой бүүр яг асууж байгаа асуулт нь бол ингээж байгаа юм л даа. Банкны хүүг бууруулж жилийн 3 хувь болгох талаар ямар арга хэмжээ авч байгаа вэ гээд. Энэ их тодорхой бас яг иргэн өөртэйгөө маш олон иргэдийн амьдралтай холбогдсон юм асуусан байна л даа. Энэ дээр ер нь банкны чиглэлээр энэ ажлын хэсэг дотор хариулт өгөх хүн байна уу үгүй юу.

Л.Мөнхбаатар: Хэн хариулах вэ ажлын хэсгээс?

Б.Энхбаяр: Энэ үдээс өмнө бид Мөнгөний бодлого баталсан тийм ээ, Улсын Их Хурал дээр. Энэ дээр л өдөржин ярьсан л асуулт байна даа. Тэгэхээр Улсын Их Хурал өнөөдөржин энийг л ярьсан даа Мөнгөний бодлого. Монголбанкны л хариулах хариулт л даа.

Д.Цогтбаатар: Тэгвэл энэ дээр би бас нэг асуулт өөрөө нэмээд асуучихмаар байна. Энэ сая бас сөрөг хүчнийхээ хэлж байгаа үгийг бид нар анхааралтай сонсож байх ёстой. Манай энэ Хууль зүйн яам бол нэг юман дээр их тодорхой хариулт өгөх ёстой байгаа юм. Юу гэвэл энэ чинь ингээд намчирхаад өөрийнхнийгөө авч үлдээд өөр нэг.../үг тасрав/

Л.Мөнхбаатар: Цогтбаатар даргаа ер нь бол иргэдээс ирсэн мэдээллийг, ирүүлсэн зүйлүүдийг л нэгтгэж асуух юм, тийм.

Д.Цогтбаатар: Би өөрөө нэмж асууж болохгүй юу?

Л.Мөнхбаатар: Түүнээс биш та хувь гишүүнийхээ хувьд асуух дэг байхгүй байгаа гэдгийг сануулаад хэлье.

Д.Цогтбаатар: Би ойлгосон.

Л.Мөнхбаатар: Иргэдээс ирсэн асуултууд байвал нь тэрийг нь асуучих, болсон уу?

Д.Цогтбаатар: Боллоо тэгвэл.

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя. Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын иргэдийн Хурлын Төлөөлөгчид, ЗДТГ-ын албан хаагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдийн ажил амьдралд хамгийн сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе. Тийм, Улсын Их Хурлын мэдээллийн цаг учраас, Ерөнхий сайдын мэдээллийн цаг учраас зөвхөн сөрөг хүчин асуудаг ийм дэгтэй байгаа гэдгийг бас хэлье. Баянхонгор аймгаас сонгогдсон эрхэм гишүүн Дашидондогийн Ганбат Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийг төлөөлж ЗГ-ын гишүүнээс асуулт асууна. Үргэлжлэх хугацаа 20 минутад багтаана. Дашидондогийн Ганбат гишүүнийг асуултаа асуухыг урьж байна.

Д.Ганбат: Баярлалаа. Бид бүхэн өнөөдөр авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох шинэтгэлийн бодлогын Ерөнхий сайдын мэдээлэлтэй танилцаад, харилцан ярилцаад сууж байна. 1 дүгээрт Ерөнхий сайд маань уул нь орж ирээд энэ бол маш чухал асуудал. Монголын нийгэмд бол үнэхээр хорт хавдар болчихсон, хүмүүсийн өдөр тутмын амьдралд нөлөөлж байгаа ийм асуудал байсаар байгаа юм. Уул нь энэ дээрээ Ерөнхий сайд өөрөө тэр ярьж байгаа бүх зүйлээ тайлбарлаад, яриад, бодлогоо танилцуулаад явсан бол ийм сайхан цаг байсан. Гэтэл өөрөө алга. Ямар учир шалтгаантай юм бэ, энэнээс илүү чухал ажил цаана нь байдаг юм уу? Би бол энэ нэг номерын л асуудал гэж бодож байна. Ингээд хүрээний уулзварыг яривал дуусахгүй байгаа гэдэг шиг.../үг тасрав/

Л.Мөнхбаатар: Ганбат дарга юу яачихъя би бас тодорхой хариулт өгчихье. Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийн цаг 14 цагаас. Гэхдээ Үндэсний аюулгүй байдлын зөвлөл хуралдаж байна. Тийм учраас ХЗДХ-ийн сайд Баттөмөрийн Энхбаяртай мэдээлэл хийсэн гэдгийг бас танд хэлье гэж бодож байна. Асуултууд, хариултуудаа явуулъя. Хэн Баттөмөрийн Энхбаяр сайдын микрофоныг бас хамт өгчхөөрэй. Ингээд асуултаа асууя.

Д.Ганбат: Ингээд хүрээний бузрыг яривал ингээд дуусахгүй. Энэ мэдээлэлтэй ингээд сонсоод яаж байхад бол ер нь тэгнэ, ингэнэ гээд дандаа ирээдүй цаг дээр л юмнууд байна л даа. Уул нь нэг нам олонх болоод, хэт олонх шүү дээ, 60-аас дээш ийм суудалтай 8 жил болчихсон байгаа. Бүрэн эрхийн хугацаа ч удахгүй нэг хэдхэн сар болоод дуусах гэж байна. Энэ хооронд бол ийм, ийм ажил хийлээ, ингэж нөхцөл байдал сайжирлаа гэж ярих ёстой. Би ингээд бас тийм ийм гээд яриад байвал та нар хүлээж авахдаа аягүй тааруу. Тэгэхээр түрүүн манай гишүүд ярьж байгаад гараад явчихлаа. Авлигын индексийг жил болгон хараат бус байгууллага олон улсын байгууллага гаргадаг Транспаренси интернэйшинл. 2016, 12, 13, 4 оны үед бол 72, 76-д оччихсон байсан. Өнөөдөр гэхэд бол 116 дээр ирчихсэн байна. Тэгээд тэр тоог ч хүртэл хэлэхээсээ хүртэл айж байна шүү дээ. Тэгээд ийм ЗГ, ийм албан тушаалтнууд авлигатай тэмцэж чадах уу? Энэ 23 оны индекс ч гэсэн нэг олигтой гарах тийм итгэл аягүй муу байгаа.

Ингээд асууя. 16 оноос хойш Концессын гэрээ гэж байгаа. Энэ хэдий их 1 тэрбум долларын гэрээ байсан, энэ асуудал юу олж дууссан бэ? 2 ЖДҮ 50 тэрбумын хэрэг байгаа, 40, 50 танай намын голдуу нөхдүүд оролцоод ингэсэн. Энэ нөхдүүдтэйгээ ямар хариуцлага тооцсон бэ? Дараа нь нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын асуудал байна. 400 тэрбум төгрөгийг байршуулаад байхгүй болгочихсон. Капитал банканд.

Энийг хариуцаж байсан Ардын намын Улсын Их Хурлын гишүүн торгууль аваад л салсан. Дараа нь бас тэр Чингис Хаан банканд байршсан мөнгө байна. Энэ Сумъяабазар гишүүнтэй холбоотой, энэ зүйл юу болсон бэ? 4.Хөгжлийн банк, 1,6 их наядыг шамшигдуулсан. Энэнээс зөвхөн 1 их наяд нь төлөгдөөд явж байгаагаас 0,6 их наяд нь сураггүй байгаа. Хэчнээн их хугацаа өнгөрч байгаа билээ? 5-д нь ковидын асуудал. Энэ 10 их наядыг баталсан, 5 их наядыг баталсан, 1 тэрбум долларын гадаадын зээл тусламж орж ирсэн. Энэ мөнгө яасан бэ? Энэний тайланг яагаад гаргаж тавьдаггүй юм бэ? Тэр байтугай зүгээр 1500 төгрөгийн маскийг 20, 30 мянган төгрөгөөр шахсан гэдэг ийм асуудал хэвлэл мэдээлэл дээр явж байгаа шүү дээ. 6.Нүүрсний асуудал, энэ бүүр ужиг болсон. Энийг бол эрх мэдэл албан тушаалтай нөхдүүд л хийдэг. 44 их наядын ийм нүүрс шамшигдуулсан гэсэн зүйлийг яригдаж байгаа. Би нүүрсний хороонд байдаг. Тэгээд би танд хүртэл санал гаргаж байсан. Энийг албан тушаалтай нөхдүүд хийдэг. Тухайн үеийн ҮАБЗ-д ажиллаж байсан нөхдүүд, ЗГХЭГ-ын даргаар ажиллаж байсан нөхдүүд бие биеийгээ нүүрсний хулгайчаар хүртэл дуудаж байгаа шүү дээ. Энэ хүмүүсийг прокурорт санал тавиад, хилийн хоригийг нь тавиулъя гэдэг санал хүртэл гаргасан. Өнөөдөр Нүүрсний хороо маань 7 сард байгуулагдаад, 5 сар болж байхад шинжээчээ ч томилж чадаагүй явж байгаа.

Дараа нь энэ төмөр зам байна. Энэ оффтейк, энэ 3 их наяд, өчнөөн тэрбум улсын мөнгийг зарцуулчихсан, татвар төлөгчдийн мөнгийг. Энийг одоо болтол ашиглаж чадахгүй байгаа. Цаашидаа ч яаж ашиглах нь мэдэгдэхгүй, хэзээ ашиглалтад орох юм бэ? Энэ ЗГ-т хамаатай юу, хамаагүй юу? 8 Хамгийн сүүлд саяхан ойрхон гарлаа автобусны хэрэг. Ногоон, улаан автобуснууд. Энд 420 тэрбумыг Сумъяабазар даргыг бид нар магтаж, магтаж байгаад л тавьж өгөөд л явуулсан. Өнөөдөр нэг ч автобус байхгүй. Одоо тэгээд Улсын Их Хурлын

гишүүнийг ард түмэн сонгоод ирчихсэн байхад Хотын дарга болгоод л ингээд л явуулдаг та нар магтаж, магтаж өгөөд л гэх мэтчилэн ийм асуудлууд байна.

Л.Мөнхбаатар: Ганбат даргын хэн гэдэг иргэн асуулт асуугаад байгааг нь бас та нэрийг дурдаж хэлэх үүрэгтэй шүү. Яагаад гэвэл иргэдээс ирсэн асуултыг л та ЗГ-ын гишүүнээс асууна.

Д.Ганбат: Иргэдээс бол Өлзийбаяр, Сарантуяа, Оюунтуяа, Батмөнх, Билгүүн, Туяацэцэг, Мөнхболд гэсэн 7 гишүүн 7 иргэн Д-парламентаар дамжуулаад 12 асуулт асуусан байна. Ерөнхий утга учир нь ийм зүйл дээр л хамрагдаад байгаа. Тэгээд таны хариултыг сонсчихоод, тэгээд цаашаа үргэлжлүүлье.

Л.Мөнхбаатар: Энхбаяр сайдын микрофоныг нь нээчих.

Б.Энхбаяр: Ганбат гишүүн бид 2 бол Хөгжлийн банкны хянан шалгах түр хороон дээр хамт зогссон, одоо Нүүрсний хянан шалгах түр хороон дээр бас хамт зогсож байгаа, хаа ч явсан хамт яваад байгаа. Тийм учраас бол ер нь Түр хороо ч байтугай гишүүдээс янз янзын юм сонсогддог. Ганбат гишүүн харин элдэв юманд оролцолдоогүй гишүүн юм шиг байна лээ. Янз янзын юм ерөөсөө гарч ирдэггүй юм байна лээ. Тийм учраас бид бас хамтдаа зогсож энэ асуудлын ард гарна, тийм. Тэр сүүлээс нь хариулахад тэр сая уржигдар 3 дахь өдөр буюу уржигдар Нүүрсний хяналтын түр хороо хуралдсан. Зарим шинжээч нарыг сольё гэдэг асуудал яригдсан. Сонирхлын зөрчилтэй шинэ нөхцөл байдал тогтоогдсон учраас миний хувьд сольё гэдэг асуудлыг тавьсан. Тэгсэн чинь манай Доржханд гишүүнээс эхлээд солихгүй гэдэг санал хураалт өгөөд байгаа юм. Камерын өмнө болохоор янз бүрийн тоо яриад, нүүрсний асуудлаа шийд гээд яриад байдаг. Яг Түр хороон дээрээ ирээд ийм сонирхлын зөрчилтэй нөхцөл байдал тогтоогдож байгаа

асуудлыг нь би ил, далд танилцуулаад энэ шинжээчээ явуулъя гэхээр явуулахгүй гээд суугаад байдаг. Тэгээд ямар учиртай юм бэ гэхээр би нэг хүн шинжээч оруулъя гээд байдаг өөдөөс микрофонгүй. Энэ Нүүрсний хяналт Улсын Их Хурлын хяналтын хяналт шалгалтын тухай хуульд зааснаар бол энэ хянаж шалгах шинжээч нар улс төрийн албан тушаалтан байж болохгүй, нам намын төлөөлөл орж шалгадаг газар биш гэж тайлбарлаад, тайлбарыг бас эс олоод байгаа асуудлууд бас байгаа.

Тийм учраас би энэ нөхцөл байдлуудыг бол цаашидаа ил тод хэлж явна. Түр хорооны даргын хувьд хэлээд байна шүү дээ. Энд ямарваа нэгэн намчирхал, дарга, цэргийн асуудал ярихгүй, хулгайчдаасаа салъя, авлигачдаасаа илчилье гээд байхад энд нь нам дамжсан байдлаар саад болж байгаа асуудлууд харин байна. Нам дамнасан асуудлаар шүү. Тийм учраас нүүрсээсээ салах нь эсвэл нүүрстэй тийм барьцаалагдчихсан, гар хөл болчихсон, дүүжлэгдчихсэн, намаа худалдчихсан нүүрсчдэд ийм байгаад байдаг юм уу. Тийм учраас энэ бодитойгоор өчигдөр ч гэсэн Улсын Их Хурлын дарга хэллээ шүү дээ. Улсын Их Хурлын чуулганы индэр дээрээс. Энэ Түр хороог тасалдалгүй хуралдуулах нөхцөл бололцоогоор хангаж өг, ханга, гишүүд хуралдаа суу, энэ чинь гишүүд хуралдаа суугаад ирц бүрдэж байж хуралдах гээд байна шүү дээ ерөөсөө. Тэгээд ирцийг нь хүргэдэггүй, хурал нь ингээд хуралдаж чадахгүй болохоор шинжээчдээ томилж чадахгүй, шинжээчдээ томилж чадахгүй болохоор шалгаж чадахгүй, дүгнэлт гаргаж чадахгүй, цаг алдаад байгаа байхгүй юу. Би тийм учраас хэлсэн шүү дээ, бидэнд нэг өдөр ч үнэтэй байна, тэр байтугай нэг цаг үнэтэй байна. Энэ хяналт шалгалтын ажилд. Асар их өргөн цар хүрээтэй ажлыг I сарын дотор үндсэндээ шалгаж, ард түмэндээ танилцуулах гээд байна шүү дээ. Тэгэхдээ хугацаа нь шахагдаж яарч, хөнгөн

дүгнэлт бол гаргахгүй, хугацаанд шахагдаж.

Би түрүүн хэлээд байгаа шүү дээ. Муу нуухаар сайн илчил гэж байгаа юм. Оюун-Эрдэнийн ЗГ юуг ч нуухыг хүсэхгүй байгаа. Монгол Улсын Ерөнхий сайд авлигатай хийх тэмцэл дээр хатуу итгэл үнэмшилтэй байгаа. Энэ бодлогоо өнгөрсөн онд улс төрд нөлөө бүхий этгээдүүд энэ хээл хахууль авч байгаа асуудал дээр өршөөл үзүүлэхгүй, бүх насаар нь хорих ялтай болох хуулийн төслийг хэн ер нь Улсын Их Хуралд оруулж батлуулж байсан юм, ямар Ерөнхий сайд оруулж ирж байсан юм бэ? Авлигачдыг хугацаанаас нь өмнө суллахгүй гэдэг хуулийн төслийг мөн оруулж ирсэн. Одоо сүүлийн жилүүдэд анхан шатын шүүхүүдээс гарч байгаа шийдвэрүүд ард иргэдийг босгох нь байна шүү. Нөгөө том, том дүнтэй авлига, албан тушаалын хэргүүдийг хэдэн төгрөгөөр торгосон болгоод толгойг нь нэлээн явуулаад байгаа юм. 2,7 тэрбум төгрөгийн хахууль авсан Хөдөлмөрийн баатрыг 20 саяар торгоно гэж ямар юмаа байдаг юм бэ ер нь? Тийм учраас ард түмний итгэлийг шударга ёсонд итгэл нурахад энэ асуудал чинь нөлөөлөөд байна. Тийм учраас Шүүх байгуулах хуулийг ирэх долоо хоногийн ЗГ-ын хуралдаанаар хэлэлцэж, Улсын Их Хуралд өргөн барих гэж байгаа юм. Энэ хуулийг дагалдуулаад Шүүх байгуулах хуулийг дагалдуулаад ЭХХШТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг өргөн барихыг Ерөнхий сайд надад даалгаад байж байгаа юм.

Би ямар өөрчлөлтүүдийг оруулах гэж байгаа вэ гэдгийг ЗГ-аар хуралдаанаар хэлэлцээд, шийдвэр гарсны дараа хэлэх нь зөв. Урьдчилаад ЗГ-аар хэлэлцээгүй байхад би ноорог яриад байх нь ЗГ-ын гишүүний зарчимд нийцэхгүй. Энэ асуудлаар системтэй арга хэмжээ авна. Мөрдөх албад, хяналтын шат, шүүхээр шийдвэрлэгдэж байгаа асуудлууд цогц хэрэг арга хэмжээ авахгүй бол энэ ерөөсөө арилахгүй юм байна лээ.

Яагаад гэхээр энэ өөрөө гүн бие шигдсэн мафи болчихсон байгаа байхгүй юу. Би түрүүн хэлээд байна шүү дээ зарим нүүрсний хэрэг чинь тэр олон жилийн өмнө илэрчихсэн мөртөө хаагдчихсан гээд. Энийг хэн хийх вэ, энийг эрх мэдэлтэй сүлжээ хийнэ. Эрх мэдэлгүй хүн хийхгүй. Тийм учраас мууг нуухгүй гэдэг л ийм л зарчмаар явна. Тийм учраас энэ ЗГ-ын энэ тэмцлийг Улсын Их Хурал маань дэмжиж ажиллаж байгаад баяртай байгаа. Би түрүүн хэлсэн Хяналт шалгалтын тухай хууль, Үндсэн хуулийн өөрчлөлтүүд ЗГ-аас орж ирж байгаа энэ авлигатай тэмцэх, ялангуяа ял шийтгэлийн бодлогыг чангаруулах энэ асуудлуудыг Улсын Их Хурал тууштай дэмжиж, бид хамтдаа баталж явж байгаа. Энэ удаагийн Улсын Их Хурал бол сайт дээр гарсан байна лээ. Эгнээнээсээ хамгийн олон гишүүдийг түдгэлзүүлчхээд байгаа гэж, гаргаад явуулчихсан байгаа гэж, тийм ээ тийм үнэн.

Энэ нь энэ удаагийн Улсын Их Хурал л хамгийн олон авлигачтай гэсэн үг биш байхгүй юу даа. Энэ удаагийн Улсын Их Хурал магадгүй, энэ удаагийн ЗГ магадгүй хамгийн авлигатай тэмцэх хүний өөрийн нам хамаагүй улс төрийн хүсэл эрмэлзэлтэй байгааг харин илтгэж байгаа ийм үзүүлэлт ч байхыг үгүйсгэхгүй. Би хэлээд байгаа шүү дээ. Хөгжлийн банкны сонсгол дээр та хэд маань орж ирээд асуулт асуучхаач гэж. 3 удаагийн сонсгол 3 сар хийсэн. Манай сөрөг хүчин яг ингэж ярьж байгаа шигээ тэр сонсгол дээр орж ирж асуулт асуугаагүй, оролцоогүй. Тэнд манай намын журмын нөхдүүд байцаагдаад зогсож байхад сөрөг хүчин тэнд жинхэнэ асууж байх ёстой байсан байхгүй юу. Тэнд чинь нотлох баримт яригдаад байна шүү дээ жинхэнэ. Хэн асууж байсан юм эрх баригчид журмын нөхөд гэж хэлэлгүйгээр бид, бид өөрсдөө асууж байсан шүү дээ. Та нар хааччихсан байсан юм бэ? Яагаад тэр ард түмний, олон түмний итгэлийг хөсөрдүүлж тэр хяналт шалгалтын ажилд энд ярьж байгаа шигээ яг нотлох баримтууд гаргаад ирэнгүүт

зугтаад алга болчхож байгаа юм бэ? АН-аас төлөөлж орсон 3 гишүүн гурвуулаа ороогүй. Ганбат дарга л хэд хоног байж байгаад, сүүлдээ та бид 2 чинь юу яалаа бас тар тур гэж байгаад та чинь нэг гомдож ирснээ, нэг баярлаж ирдэг ч билүү нэг ингээд хэсэг суусан шүү дээ.

Нөгөө 2 бүүр байхгүй. Тэгээд сүүлдээ Доржханд, Сүхбаатар бид 3 л байсан, бараг дийлэнхдээ яав уу яав. Энэ чинь ийм байж болохгүй шүү дээ. Хамтын, олонхын, цөөнхийн хамтын оролцоотойгоор ингээж байж бид нар энэ парламентын ардчиллаа ард нь гарах ёстой шүү дээ. Тэгээд л хулгай, авлигал ярихаар нам яриад л.

Д.Ганбат: Яах юм, болчхож байгаа юм уу, ярих уу цаашаа. Хууль зүйн сайдынхаа бас сайхан цогтой үгнүүдийг сонсож байна. Юу яая ийм байна шүү, одоо жоохон улс орныхоо хэмжээний юм руу орё. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны зарлага бол 13,9 их наяд байсан байна, одоо ингээд өнөөдөр ингээд 24 оны төсөв батлагдлаа, 27,4 их наяд болж байгаа юм. Тэгээд энэ 3, 3-хан жилд бол 2 дахин буюу 13,5 их наядар нэмэгдэж байгаа юм. Энэ ингээд ийм их мөнгийг улсын төсөв дээр төвлөрүүлнэ гэдэг чинь энэ авлигыг бараг дэмжиж байна л гэсэн ийм ойлголт. Миний ойлголтоор бол. Нөгөө хувийн хэвшлийн орон зай ажиллах боломж энэ тэр бол багасаж байна.

Нөгөө талаар бол та бас Хууль зүйн сайд маань албан ёсоор Ганбат гэдэг гишүүнийг бол шалгаад, шалгаад, эсвэл янз бүрийн газраас юу ч олдохгүй юм гэж ингээд ийм цэвэр хүн байна гэж ингээж хэлж байгаа нь бол маш сайн байна. Улам энийгээ барьж хичээж ажиллана. Тэр тусмаа манай сонгогчдыг орж ирж байгаа үед хэллээ, их сайн байна. Тэгээд юу яая, тэгээд ийм байх юм бас. Нэгэнт ЗГ-ын мэдээлэл сонсож байгаа болохоор ЗГ-ын өр бол 2016 онд бол 4 тэрбум байсан байна. Энэ чинь 90-ээс 2016 гэхээр чинь 36 жилийн хугацаанд шүү дээ.

Тэгтэл одоо 16-аас 23 онд бол юу 8,2 тэрбум болсон байна. Энэ чинь одоо тэгээд 4,2 тэрбумаар 2 дахин илүү нэмэгдчихжээ. Нийт өр бол 16 онд 24 байгаад, 2023 онд 33 тэрбум болчихсон байна. Өнөөдөр 3 хүний нэг нь ядуу байсан бол бараг 2 хүний нэг нь ядуу болчихсон. Монгол Улс дундаж давхарга байхгүй болчихсон. Нэг ийм нөхцөл байдалтай байна. Хууль зүйн сайдын хэмжээнд энэ асуултад хариулах нь ЗГ-ын гишүүний хэмжээнд бол байгаа байх гэж ойлгож байна. Энэ дээр та бүхэн цаашидаа бид нарын барьж байгаа бодлого, энэ асуудалд хандаж байгаа хандлага чинь болохгүй байгаа юм биш үү. Энэ дээрээ эргэлт хийхгүй бол энэ маягаар яваад бол авлигатай үр дүнтэй сайн тэмцэж байна гэсэн ийм зүйл ярих хүндрэлтэй байх. Тэгээд бас танаас өөрөөс чинь нэг асуулт асуугаарай гэж хэлсэн. Олон сангууд байгаа 24, 25 сан. Тэр дотор Боловсролын зээлийн сан гэж бий. Их олон хүн холбогдсон, Хууль зүйн сайд та ч гэсэн бас холбогдсон байна.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээллийг сонслоо. Ажлын хэсэгт баярлалаа.

15.44 цаг

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА